

УСНЫ ГАЗРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/Д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Усны нөөц, түүнийг зохистой ашиглах усны талаарх хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйгээр хангах							
<i>Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 3.5.1.7, Алсын хараа -2050 урт хугацааны хөгжлийн бодлого 6.3.9, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 5.1.11, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.3.2, БОАЖЯ-ны стратегийн зорилт 1.3, Агентлагийн үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн 2.3.2.3.</i>							
1	Зорилт 1. Усны нөөцийг хомстохоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлэх, голын голдирлыг өөрчлөх, урсцад тохируулга хийх	Улсын төсөв 240.0 сая.төг Усны нөөц, нуур, гол мөрний менежмент 446.8 сая.төг	Ажлын зураг ТЭЗҮ Хөв цөөрмийн тоо	Ажлын зураг -1 ТЭЗҮ-1 Хөв цөөрмийн тоо -1	Увс, Хэнтий аймгуудын нутагт гадаргын усыг хуримтлуулах, нөхөн сэргээх ажлын зураг, ТЭЗҮ хийгдсэн байна. Өвөрхангай аймагт хөв цөөрөм 1 шинээр баригдсан.	Хэнтий аймгийн Дадал сумын “Гурван нуурын усны нөөцийг нэмэгдүүлэх зураг төсөв”-ийн ТЭЗҮ, техникийн зураг хийх ажлын урьдчилсан шатны ТЭЗҮ-ийн тайлан хүлээн авсан. Өвөрхангай аймгийн Нарийнтээл суманд “Их булаг” хөвийг шинээр байгуулсан. Увс аймгийн Хяргас сумын Билүүгийн голын хөв цөөрмийн хамгаалалтыг сайжруулсан. Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Уньт багийн Их булгийн эхийг хамгаалсан.	100 хувь
1.1	Арга хэмжээ 1.1.1 Хэнтий аймгийн Дадал сумын нутаг дахь Гурван нуурын усны нөөцийг нэмэгдүүлэх	Улсын төсөв 239.4 сая.төг	ТЭЗҮ Техникийн зураг	Судалгааны урьдчилсан тайлан хийгдсэн.	<i>Эхний хагас жил:</i> Дунд хугацааны тайланг хүлээн авсан байна. <i>Жилийн эцэс:</i> ТЭЗҮ, техникийн	“Гурван нуурын усны нөөцийг нэмэгдүүлэх зураг төсөв /Хэнтий, Дадал сум/” БОАЖЯ/202211019 дугаартай гэрээний нэмэлт гэрээг “Престиж инженеринг” ХХК-тай 2023.01.02-ны өдөр	100 хувь

					зургийг хүлээн авсан байна.	гүйцэтгэгчтэй байгуулж хэрэгжүүлсэн. Тус ажлын хүрээнд Гурван нуур нь хур тунадас, гадаргын уснаас гадна өнгөн хөрсний ус, газрын гүний усны тэжээлтэй, эргэн тойрондоо хүлэрт намгаар хамгаалагдсан орчны бичил экосистемийн онцлог бүхий сав газарт орших бөгөөд тухайн жилийн уур амьсгал, услагийн нөхцөл байдал, хүний үйл ажиллагааны нөлөөллөөс хамаарч нуурын усан гадаргын талбай, эзлэхүүн жилээс жилд өөрчлөгдөж байгааг судалж тодорхойлсон. Гурван нуурыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хөрөнгө оруулалтын төсөөллөөр нийт 1,257.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардагдахаар байна. Энэ хөрөнгийн санхүүжилтийн 53%-ийг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 19% ийг гадаадын зээл тусламжаар, 28%-ийг хувийн болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Гурван нуурын усны нөөцийг нэмэгдүүлэх ажлын техник эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсан. /2022 онд 60.0 сая.төг-ийн санхүүжилт хийсэн ба 2023 онд 239.4 сая.төг-ийн санхүүжилт хийгдэнэ/.	
1.2	Арга хэмжээ 1.2.1 "Их булаг" хөв цөөрөм байгуулах /Өвөрхангай аймаг, Нарийн тээл сум/	Усны нөөц, нуур, гол мөрний менежмент 396.8	Ажлын даалгавар	Ажлын зураг төсөл хийгдсэн	<i>Эхний хагас жил:</i> Ажлын даалгавар боловсруулж батлуулсан байна.	"Их булаг" хөв цөөрөм байгуулах (Өвөрхангай, Нарийнтээл) ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог	100 хувь

		сая.төг	Ажил гүйцэтгэх үе шат		Зөвлөхийг сонгон шалгаруулсан байна. <i>Жилийн эцэс:</i> Барилгын ажлыг улсын комиссын актаар хүлээн авсан байна.	Усны газрын даргын 2023.03.07-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар байгуулсан. Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын "Их булаг" хөв байгуулах ажил гүйцэтгүүлэх УГ/202301012 дугаартай гэрээг 2023.05.22-ны өдөр "Усны барилга" ХХК-тай байгуулсан. Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын нутагт "Их булаг" хөв цөөрмийн барилга угсралтын ажлыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр "Усны барилга" ХХК гүйцэтгэсэн. Өвөрхангай аймгийн засаг даргын А/543 дугаар захирамжаар 16 хүний бүрэлдэхүүнтэй комисс ажиллан 2023.09.04-нд хүлээн авч, Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн.	
1.3	Арга хэмжээ 1.3.1 Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Уньт багийн Их булгийн эхийг хамгаалах	Усны нөөц, нуур, гол мөрний менежмент 10 сая.төг	Ажлын даалгавар Ажил гүйцэтгэх үе шат Эхийг хамгаалсан булгийн тоо	Шинээр хийгдэнэ	<i>Эхний хагас жил:</i> Их булгийн эхийг хамгаалах ажлыг гүйцэтгэгчийн сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байна. <i>Жилийн эцэс:</i> Булгийн эхийг хамгаалах ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, ажлын үр дүнг хүлээн авсан байна.	Усны газрын даргын 2023.04.04-ны А/28 дугаар тушаалаар Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Уньт багийн Их булгийн эхийг хамгаалах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог байгуулсан. Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Уньт багийн Их булгийн эхийг хамгаалах ажил гүйцэтгэх гэрээг 2023.04.07-ны өдөр "Их булаг хөгжил" ТББ-тай байгуулсан. Их булгийн эхийг хамгаалах ажлыг хийж дуусган Сэлэнгэ голын СГЗ-д 2023.09.15-нд гүйцэтгэлийн тайланг хүлээлгэн өгсөн.	100 хувь

1.4	<p>Арга хэмжээ 1.4.1. Монгол орны томоохон голууд дээр урсцын тохируулга, усан цахилгаан станц байгуулах, шилжүүлэн ашиглах боломжийн талаарх судалгаа хийх, боломжтой газруудад зураг төсөл зохиох</p>	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт	Ажлын даалгавар ТЭЗҮ тодотгол Ажлын зураг БОНБНУ	Ажлын даалгаврын төсөл хийгдсэн.	<p><i>Эхний хагас жилд:</i> Төслийн нэгж байгуулах-1, Хэнтий аймагт “Хэрлэн-Тооно” төслийн ТЭЗҮ-ийн тодотгол -1, <i>Жилийн эцэст:</i> Судалгааны тайлан Ажлын зураг-1, БОНБНУ -1.</p>	<p>Хэрлэн-Тооно төслийн ТЭЗҮ тодотгох ажлын даалгаврыг боловсруулж 2023.01.18-ны өдрийн 01/49 тоот албан бичгээр “Эрдэнэс Оюутолгой” ХХК-д хүргүүлсэн.</p> <p>ТЭЗҮ-ийн тодотгол хийх санхүүжилтийг “Оюутолгой” ХХК шийдвэрлэсэн. Нийт төсөвт өртөг 3 сая ам.доллар. Усны газар, “Эрдэнэс Оюутолгой” ХХК, Оюутолгой ХХК-тай хамтарсан хурлыг 3 удаа хийж, ТЭЗҮ тодотгох ажил болон судалгааны ажлын талаар нарийвчлан хэлэлцэж санал авсан. “Хэрлэн-тооно” төслийн ТЭЗҮ-ийн судалгааг шинэчлэх, тодотгол хийж боловсруулах ажлын даалгаварт дээрх саналуудыг тусган Усны газраар ажлын даалгаврыг дахин баталж, 2023.09.06-ны 01/1032 тоот албан бичгээр хүргүүлсэн. Тендерийн баримт бичгийг боловсруулан 2023.12 сард тендер зарлахаар үнэлгээний хороо байгуулсан.</p> <p>Онгийн гол /Цагаан бургастайн боомт/-ын төслийн БОНУ, ажлын зураг хийх төсвийн төсөл хийж ЭЗХЯ-д хүргүүлсэн боловч 2023 онд батлагдаагүй. Уг төслийн хүрээнд санхүүжилтийг шийдвэрлүүлэх зорилгоор 2023.04.07-нд Уур амьсгалын ногоон сангийн 2-р хөтөлбөрийн төслийг хэлэлцүүлэх зөвлөлдөх уулзалтад Хэрлэн тооно, Онги Цагаанбургастайн төслийн талаар танилцуулсан. “Орхон-Онги” төслийн хураангуй танилцуулга</p>	100 хувь
-----	--	----------------------------------	---	----------------------------------	---	---	----------

						бэлтгэн орчуулах ажлыг хийж, Ерөнхийлөгчийн тамгын газар, Гадаад харилцааны яаманд 2023.05.31-нд хүргүүлсэн. Онги Цагаанбургастайн төслийн хүрээнд Говийн бүсийн 4 аймгийн 11 сумын 40 гаруй мянган хүн амын унд-ахуйн хэрэгцээний усаар найдвартай хангах, Улаан нуурын усны түвшинг нэмэгдүүлэх, уул уурхайн ус хангамжийг сайжруулах зорилгоор Онги-Улаан нуур-Тавантолгой ус дамжуулах байгууламжийн ТЭЗҮ, техникийн зураг төслийг 2022-2023 онд Өмнөговь аймгийн ЗДТГ-ын захиалгаар "Гидродизайн инноваци" ХХК хийж гүйцэтгэсэн.	
1.5	Арга хэмжээ 1.5.1. Увс аймгийн Хяргас сумын Билүүгийн голын эргийн хамгаалалтын ажил	Усны нөөц, нуур, гол мөрний менежмент	Эргийн хамгаалалт Тохижилт	Ажлын зураг төсөл хийгдсэн.	<i>Эхний хагас жилд:</i> Ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. <i>Жилийн эцэст:</i> Эргийн хамгаалалт – 1 Тохижилт-1	Усны газрын даргын 23.05.12-ны өдрийн А/36 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулсан. Харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх тендерийн баримт бичгийг боловсруулж, газрын даргаар батлуулж, ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, "ССТ-ОД" ХХК-тай 2023.08.21-ний өдөр УГ/202301006 дугаартай гэрээ байгуулсан. Эргийн хамгаалалтын ажлыг "ССТ-ОД" ХХК хийж гүйцэтгэн Усны газрын даргын 2023.10.30-ны өдрийн А/88 дугаар тушаалаар батлагдсан 9 хүний бүрэлдэхүүнтэй комисс 2023.11.06-ны өдөр ажиллан эргийн хамгаалалтын ажлын	100 хувь

						хүлээн авч, Увс аймгийн Хяргас сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн.	
1.6	Арга хэмжээ 1.6.1 Баян-Айрагийн гол дээр хөв цөөрөм байгуулах зураг төсөл боловсруулах /Увс аймаг, Баруунтуруун сум/	Усны нөөц, нуур, гол мөрний менежмент 50.0 сая.төг	Ажлын даалгавар Ажил гүйцэтгэх үе шат	Шинээр хийгдэнэ.	<i>Эхний хагас жил:</i> Ажлын даалгавар боловсруулж батлуулсан байна. Зөвлөхийг сонгон шалгаруулсан байна. <i>Жилийн эцэс:</i> Ажлын зураг - 1	2023 онд төсөв батлагдаагүй.	-
Стратеги төлөвлөгөөний зорилго 2. Усны нөөцийг бохирдол, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, цэвэрлэсэн болон саарал усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах							
<i>Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 3.5.1.8, Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлого 6.3.1, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 5.1.3, Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн арга хэмжээний төлөвлөгөөний 4.4, Агентлагийн үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн 2.5.3.1, 2.5.3.2, Засгийн газрын 2020 оны 193 дугаар тогтоол.</i>							
2	Зорилт 2. Усны хэрэглээг тоолууржуулж, ус ашиглалтын үр ашиг, хэмнэлтийг сайжруулна.	Төсөв	Тоолуур суурилуулсан ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгжийн тоо	Ус ашиглалтыг тоолууржуулсан аж ахуйн нэгж 1655 байна.	Усны алдагдлыг багасгахад хяналт тавих зорилгоор ус ашиглагч иргэн аж ахуйн нэгжийн тоолууржуулалтын тоог нэмэгдүүлсэн байна.	Усны хэрэглээг тоолууржуулж, ус ашиглалтын үр ашиг, хэмнэлтийг сайжруулсан.	100 хувь
2.1	Арга хэмжээ 2.1.1 Аж ахуйн нэгж байгууллагуудад усыг зохистой ашиглах, усны нөөцийг хэмнэх, тоолууржуулах ажлыг эрчимжүүлэх, усны алдагдлыг бууруулах, ус ашиглалтыг бодитоор тооцох нөхцөлийг бүрдүүлж тоолууржуулах ажлыг эрчимжүүлэх, тайлагнах хэрэгжилтэд хяналт тавих;	Төсөв шаардахгүй	Тоолуур суурилуулсан ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгжийн тоо	Тоолууржуулалтын мэдээ, тайланг 100% нэгтгэсэн, тоолуур суурилуулсан аж ахуйн нэгжийн тоо 1706 байна.	<i>Эхний хагас жил:</i> Тоолууржуулалтын мэдээ, мэдээллийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэн гаргасан байна. <i>Жилийн эцэс:</i> Ус ашиглагч аж ахуйн нэгжүүдийг тоолууржуулах, усны алдагдлыг багасгах чиглэлээр зөвлөмж хүргүүлж, хяналт тавих,	Улсын хэмжээнд усны нөөцийг хэмнэх зорилгоор усны хэрэглээг тоолууржуулах ажлыг удирдлага, арга зүйгээр ханган Сав газрын захиргаа, Аймаг, Нийслэлийн БОАЖГ-аас 2023 онд нийт 6582 усны тоолуур суурилуулахад нийт 807.15 сая төгрөг зарцуулсан дүн мэдээг нэгтгэж, ажилласан. Мөн хаягдал усны дүгнэлт гаргах замаар 126 аж ахуйн нэгж байгууллагад тоолуур суурилуулах шаардлагатай талаар дүгнэлт, зөвлөмж хүргүүлэв.	90 хувь

					холбогдох газруудаас тоолууржуулалтын мэдээллийг авч нэгтгэсэн байна.		
3	<p>Зорилт 3. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.</p>	Улсын төсөв	<p>Туул голын ёроолын хурдсыг цэвэрлэх.</p> <p>Хөвсгөл нуурын экосистемийн бохирдлын эрсдэлийн судалгааг хийж, нуурт живсэн машин техникийг татаж гаргах.</p>	<p>Шинээр хийгдэнэ.</p> <p>2020-2025 онд хийж хэрэгжүүлнэ.</p>	<p>Туул голын 35-40 км ёроолын хурдсыг цэвэрлэсэн байна.</p> <p>Хөвсгөл нуурын экосистемийн бохирдлын эрсдэлийн судалгааг хийж, нуурт живсэн машин техникийг татаж гаргах ажлын хэсгийг мэдээллээр хангаж ажилласан байна.</p>	<p>Нэгтгэсэн тайлан мэдээ – 2 Боловсруулсан хөтөлбөр-1 Батлуулсан тушаал-3 Ажлын даалгавар-1 Тоног төхөөрөмж худалдан авалтад хөрөнгө 96.5 сая.төг</p>	100 хувь
3.1	<p>Арга хэмжээ 3.1.1 Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжаас доош Туул голын голдирол дагуу 35-40 км орчим ёроолын хурдсыг цэвэрлэх;</p>	Улсын төсөв	<p>Туул голын ёроолын хурдас цэвэрлэх ажлыг зохион байгуулсан байна.</p>	<p>Шинээр хийгдэнэ.</p>	<p><i>Эхний хагас жил:</i> Хурдас цэвэрлэх ажлын даалгаврыг боловсруулж батлуулсан байна.</p> <p><i>Жилийн эцэс:</i> Ажил гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, Туул голын ёроолын хурдсыг цэвэрлэсэн байна.</p>	<p>Туул голыг цэвэрлэх зорилгоор “Голын ёроолын хурдсыг цэвэршүүлэх техник хэрэгсэл”-ийг хүлээн авч, техникийг ажиллуулахад шаардлагатай 380 вольтын 100KW хүчин чадал бүхий дизель генератор – 1ш, 40 тонны даацтай дугуйт чиргүүл – 1ш, 2500 л/мин, 30hp/22kw хүчин чадал бүхий компрессор -1ш, 30л/мин дамжуулах хурдтай 50 м урт туузан дамжуулагч -1ш, тус бүр 50 м урт, 150 мм голчтой ус дамжуулах 2ш уян хоолойг авах “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжаас гарч байгаа хаягдал, бохир ус Туул голд нийлсэн хэсгийн лаг хагшаасыг цэвэрлэх ажлын</p>	80 хувь

						даалгавар"-ыг Усны газрын даргаар батлуулж, зардлыг Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны хөрөнгөөр Усны газарт худалдан авах БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/355 дугаар тушаал, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2023 оны 23/06 дугаар тогтоол тус тус гаргуулан худалдан авах ажиллагааг зарлаж, "Батцариг" ХХК-тай 47 дугаартай, "Хонин констракшн" ХХК-тай 48 дугаартай дугуйт чиргүүлээс бусад тоног төхөөрөмжийг нийлүүлэх гэрээг байгуулж, гадна агаарын температурыг нэмэх хэмд хүрэхээр ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангасан.	
3.2	<p>Арга хэмжээ 3.2.1</p> <p>Хөвсгөл нуурын экосистемийн бохирдлын эрсдэлийн судалгаа хийж, нуурт живсэн машин техникийг татаж гаргах ажлын хүрээнд нуурын усны чанар, найрлага, хомстох, бохирдохоос сэргийлэхтэй холбоотой мэдээ, мэдээллийг гаргах;</p>	Төсөв шаардахгүй	Холбогдох мэдээ, мэдээллийг цаг тухайд нь гаргаж хүргүүлсэн байна.	ЗГ-ын 2020 оны 195 дугаар тогтоол, БОАЖС-ын А/74 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	<p><i>Эхний хагас жил:</i> Ажлын хэсгийн хүрээнд шаардлагатай мэдээ, материалыг гаргаж, удирдлагад хүргүүлж, мэдээ, мэдээллээр хангасан байна.</p> <p><i>Жилийн эцэс:</i> Ажлын хэсгийн хүрээнд шаардлагатай мэдээ, материалыг гаргаж, удирдлагад хүргүүлж, мэдээ, мэдээллээр хангаж ажилласан байна.</p>	<p>Нуурын усны чанарт нөлөөлөх эрсдэлийг бууруулахад чиглэсэн иж бүрэн судалгааг хийж, хөтөлбөр боловсруулан, төсвийн саналыг боловсруулж холбогдох газарт хүргүүлсэн /boldbayar@met.gov.mn/ Хөвсгөл нуур орчмын аялал жуулчлалын үйлчилгээ эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад гаргасан ус ашиглуулах дүгнэлт, хаягдал усны дүгнэлтийн мэдээллийг СГЗ болон Хөвсгөл аймгийн БОАЖГ-аас авч нэгтгэн холбогдох газар /nyamsuren@met.gov.mn/-т хүргүүлсэн.</p> <p>Хөвсгөл нуурын Марааны булангийн эргээс 2500 орчим метр зайтай, 128 метрийн гүнд</p>	100 хувь

						1995 онд живсэн шатахуун тээврийн 58-12ХӨ улсын дугаартай (Ч47-13) “ЗИЛ-130” загварын 17.8 тонн жинтэй чиргүүлтэй автомашиныг, 1985 онд живсэн “Сүхбаатар” хөлөг онгоцыг, Дүбэрлэг уул нуурын эргээс 700 орчим метр зайд, 72 метрийн усны гүнд живсэн шатахуун тээврийн 57-07 АЧ улсын дугаартай чиргүүл, Жиглэгийн давааны ам нуурын эргээс 1.4 километрийн зайд 54 метрийн усны гүнд живсэн 6 тн шатахуун тээврийн автомашины ёмкостиг илрүүлж тус тус татан гаргасан дүн мэдээг ажлын хэсэгт хүргүүлж, мэдээллээр ханган ажиллав.	
3.3	<p>Арга хэмжээ 3.3.1 Төв Азийн орнуудад нийтийг хамарсан арга хэмжээний үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний хүрээнд усны аюулгүй байдлын стандартыг олон улсын мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулах;</p>	Төсөв шаардахгүй	Усны аюулгүй байдлын Төв Азийн орнуудад мөрдөгдөх стандартыг хамтран боловсруулсан байна.	Шинээр хийгдэнэ.	<p><i>Эхний хагас жил:</i> Усны аюулгүй байдлын Төв Азийн орнуудад мөрдөгдөх стандартын ерөнхий загварыг олон улсын мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулсан байна.</p> <p><i>Жилийн эцэс:</i> Усны аюулгүй байдлын Төв Азийн орнуудад мөрдөгдөх стандартыг боловсруулж тайланг хүлээн авсан байна.</p>	Усны газраас усны үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор Төв Азийн орнуудад нийтийг хамарсан арга хэмжээний үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах усны аюулгүй байдлын стандартын ерөнхий загварыг олон улсын мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулж, 2023.11.06-07-ны өдрүүдэд БОАЖЯ-ны дэргэдэх Биоаюулгүй байдлыг хангах үндэсний хороо, Европын Холбооны Хими, биологи, цацраг, цөмийн эрсдэлийг бууруулах тэргүүн санаачилгын төв, Олон Улсын шинжлэх ухаан технологийн төвтэй тус тус хамтран “Нийтийг хамарсан үйл ажиллагааны үеийн ундны усны аюулгүй байдлыг хангах нь” сэдэвт 2 өдрийн сургалтыг усны	100 хувь

						салбарын төрийн байгууллагуудын албан хаагчид болон усны шинжилгээний лабораториудын ажилтныг хамруулан зохион байгуулж, оролцогчдод сургагч багшийн сертификат олгосон.	
Стратеги төлөвлөгөөний зорилго 3. Усны нөөцийг судалж тогтоох, усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, нөхөн сэргээх, бохирдохоос урьдчилан сэргийлэх, усны сав газрын менежментийн тогтолцоог бэхжүүлэх							
<i>Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр ийн 5.1.2, 5.1.6, 5.1.10, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.3.1, 6.3.3, 6.3.4, УННМТ-ий 1.1, 1.2, 1.9, "Алсын хараа 2050" хөтөлбөрийн зорилго 6.3, Агентлагийн үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн 2.4.1.</i>							
4.	Зорилт 4. Усны нөөцийг тогтоож, хүн амыг баталгаат ундны усаар хангах, усны эх үүсвэрийг хамгаалах;	Улсын төсөв	Шаардлага хангасан ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувь Нөөцийг үнэлэх шаардлагатай рашааны судалгаа	Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувийг 2022 онд 82% -д хүрсэн. 2022 онд рашааны нөөцийн дахин үнэлгээ хийсэн орд-1	Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувийг 0.03 хувиар нэмэгдүүлнэ. Нөөцийг үнэлэх шаардлагатай рашааны судалгаа-1	Хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул судалгааны ажлын гүйцэтгэж, шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувийг 0.03 хувиар нэмэгдүүлсэн. Нөөцийг үнэлэх шаардлагатай рашааны судалгаа гаргасан. Гидрогеологийн дунд масштабын зураглал хийгдсэн газар нутгийн хэмжээг 17.3%-д хүргэсэн.	100 хувь
4.1.	Арга хэмжээ 4.1.1 Хот, суурин газрын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоох хайгуул, судалгааны ажлыг зохион байгуулах	Улсын төсөв	Шаардлага хангасан ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувь	2022 онд 2 сум, суурин газрын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн эрэл хайгуулын судалгааг хийсэн. Газрын доорх усны ашиглах боломжит нөөцийг 11	Эхний хагас жил: Булган аймгийн Дашинчилэн сумын төвийн ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул судалгааны ажлын даалгаврыг боловсруулж, гүйцэтгэгийг сонгон	2023 онд Булган аймгийн Дашинчилэн сумын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоох хайгуул, судалгааны ажлыг Үнэлгээний хороог Усны газрын даргын 2023 оны А/15 дугаар тушаалаар байгуулсан. Зөвлөх үйлчилгээний ажлыг 2023.03.02-ны өдөр зарлаж, 2023.05.09 өдөр гүйцэтгэгийг шалгаруулсан бөгөөд "Хужирт сэртэн" ХХК шалгарч,	100 хувь

				л/сек-ээр нэмэгдүүлсэн. Шаардлага хангасан ундны усаар хангагдсан хүн амын тоог 6900-аар нэмэгдүүлсэн.	шалгаруулсан байна. <i>Жилийн эцэс:</i> Газрын доорх усны хайгуул, судалгааны ажлын явцад хяналт тавьж, судалгааны тайланг хүлээн авч, нөөцийг баталгаажуулсан байна.	2023.05.18-ны өдөр УГ/202301011 дугаартай гэрээ байгуулсан. Тус судалгааны хээрийн ажлын явцад 2023.09.28-ны өдөр хяналт тавьж, ажлын гүйцэтгэлтэй танилцаж, холбогдох санал, зөвлөмж өгч ажилласан. “Хужирт сэртэн” ХХК судалгааны ажлын үр дүнгийн тайланг 2023.12.01-ны өдөр хүлээн авсан.	
4.2.	Арга хэмжээ 4.2.1: Рашааныг зохистой ашиглах, хамгаалах ажлыг зохион байгуулах;	Төсөв шаардахгүй	Нөөцийг үнэлэх шаардлагатай рашааны судалгаа	2022 онд нөөцийн үнэлгээ хийсэн рашааны орд-1 (Оргил рашааны нөөц – 25.2 м ³ /7цаг-хон, хувийн хөрөнгөөр)	<i>Эхний хагас жил:</i> Рашааны нөөцийг үнэлэх шаардлагатай ордуудын судалгааг гаргана. <i>Жилийн эцэс:</i> Рашааны ордуудын ашиглалтын байдалд хяналт тавьж, 1-ээс доошгүй рашааны ордын нөөцийн үнэлгээ хийх үндэслэл боловсруулсан байна.	Монгол улсын хэмжээнд хайгуул судалгаа хийж, нөөцийг баталгаажуулсан 25 рашааны орд байна. Үүнээс эхний ээлжид 5 рашааны ордын нөөцийн дахин үнэлгээг хийх шаардлагатай байна. Монгол орны рашааны ордуудын гидрогеологийн болон гидробиологийн судалгаа хийх, монгол орны рашааны нэгдсэн каталоги, мэдээллийн сан үүсгэх ажлыг 2024 онд “Усны нөөц, нуур, гол мөрний менежментийн хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэх төсвийн саналыг хүргүүлсэн. 2023 онд улсын хэмжээнд нийт 8 рашааны эхийг хамгаалсан. Үүнд: Архангай аймагт 4, Булган аймагт 1, Завхан аймагт 1, Өвөрхангай аймагт 1 рашааны эхийг хамгаалсан.	100 хувь
4.3.	Арга хэмжээ 4.3.1. Газрын доорх усны нөөцийг тогтоох, ашиглах боломжит нөөцийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах.	Хувийн хэвшлийн хөрөнгө	Хувийн хөрөнгөөр хийсэн газрын доорх усны хайгуул	2022 онд газрын доорх усны 8 ордын нөөцийг баталгаажуулж, улсын усны	<i>Эхний хагас жилд:</i> Хувийн хөрөнгөөр хийх газрын доорх усны хайгуул судалгааны ажлын даалгаврыг хянан	Аж ахуйн нэгж байгууллагын хувийн хөрөнгөөр хийхээр төлөвлөсөн газрын доорх усны хайгуул судалгааны 9 ажлын даалгаврыг хянаж, газрын даргаар батлуулсан.	100 хувь

			судалгааны ажлын тоо	мэдээллийн санд бүртгүүлсэн.	<p>баталгаажуулж, хээрийн ажлын гүйцэтгэлт хяналт тавьж, мэргэжил аргазүйн зөвлөмжөөр хангаж ажиллана.</p> <p><i>Жилийн эцэст:</i> Усны нөөцийн зөвлөлийн хуралдааныг 2-оос доошгүй удаа зохион байгуулж, 4-өөс доошгүй ордын усны нөөцийг баталгаажуулж, тайланг улсын усны мэдээллийн санд хүлээлгэн өгсөн байна.</p>	<p>Тайлант хугацаанд газрын доорх усны хайгуул судалгааны 6 хээрийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил аргазүйн зөвлөмжөөр хангаж ажилласан.</p> <p>Хувийн хөрөнгөөр усны мэргэжлийн байгууллагын гүйцэтгэсэн 8 газрын доорх усны хайгуул судалгааны ажлын үр дүнгийн тайланд шүүмжлэгч томилох тухай тушаалыг газрын даргаар батлуулж, шүүмжлэгчийн дагуу тайланд холбогдох засварыг хийлгэсэн.</p>	
4.4	<p>Арга хэмжээ 4.4.1.</p> <p>Гидрогеологийн дунд масштаб (1:200000)-ын зураглалын ажил хийх</p>	<p>Усны нөөц, нуур, гол мөрний менежмент</p> <p>300 сая.төг</p>	<p>Гидрогеологийн дунд масштабын зураглал хийсэн газар нутгийн эзлэх хувь</p>	<p>2022 онд гидрогеологийн дунд масштабын зураглалын ажлыг нийт нутаг дэвсгэрийн 16.6%-д хүргэсэн.</p>	<p><i>Эхний хагас жилд:</i> Гидрогеологийн дунд масштабын зураглал хийх ажлын даалгаврыг батлуулах, сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулсан байна.</p> <p><i>Жилийн эцэст:</i> Гидрогеологийн дунд масштабын зураглалын ажлын тайланг хүлээн авч, зураглал хийсэн газар нутгийг 17.1%-д хүргэсэн байна.</p>	<p>“Гидрогеологийн дунд масштабын зураглалын ажлыг өргөжүүлэх” зорилтын хүрээнд 2023 онд Өмнөговь аймгийн Манлай, Цогтцэций, Дундговь аймгийн Өлзийт, Дорноговь аймгийн Мандах сумын нутагт (L-48-XXXV, L-48-XXXVI) 1:200000 масштабтай зураглалын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр хийсэн.</p> <p>Үнэлгээний хороог Усны газрын даргын 2023 оны А/16 дугаар тушаалаар байгуулсан. Зөвлөх үйлчилгээний ажлыг 23.03.20-нд зарлаж, 2023.05.11-ний өдөр гүйцэтгэгчийг шалгаруулсан бөгөөд "Дунар-Од" ХХК шалгарч, 2023.05.18-ны өдөр УГ/202301008 дугаартай гэрээ</p>	100 хувь

						байгуулан ажилласан. Тус ажлын гүйцэтгэлийн тайланг Усны газарт ирүүлсэн бөгөөд ажлын үр дүнд гидрогеологийн дунд масштабын зураглал хийгдсэн газар нутгийн хэмжээг 17.3%-д хүргэсэн.	
5.	<p>Зорилт 5. Монгол Улсын төрөөс усны талаар баримталж буй бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэхэд орон нутгийн болон салбар дундын зохицуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах;</p>	Төсөл хөтөлбөр	<p>Сав газрын УННМТ-ний төсөл</p> <p>Зохион байгуулсан арга хэмжээний тоо</p>	<p>Сав газрын УННМТ-ний төсөл - 3</p> <p>Зохион байгуулсан арга хэмжээний тоо - 2</p>	<p>Сав газрын УННМТ-ний төсөл-2</p> <p>Улсын болон сав газрын УННМТ-ний хэрэгжилтийг эрчимжүүлэх, сав газрын захиргаадыг бэхжүүлэх чиглэлээр 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна.</p>	<p>Сав газрын УННМТ-ний төсөл-2, Улсын болон сав газрын УННМТ-ний хэрэгжилтийг эрчимжүүлэх, сав газрын захиргаадыг бэхжүүлэх чиглэлээр 2 арга хэмжээ зохион байгуулсан.</p>	100 хувь
5.1	<p>Арга хэмжээ 5.1.1 Төрөөс усны талаар баримтлах дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүд болон сав газрын УННМ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцогч талуудыг уялдааг сайжруулах, чадавхжуулах ажлыг зохион байгуулах</p>	Төсөл хөтөлбөр	<p>Зохион байгуулсан арга хэмжээний тоо</p>	<p>Зохион байгуулсан арга хэмжээний тоо-3</p>	<p><i>Эхний хагас жил</i> УННМТ-ний хэрэгжилтийг эрчимжүүлэх, захиргаадын үйл ажиллагааг бэхжүүлэх, талуудыг оролцоог хангах чиглэлээр 1-ээс доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна.</p> <p><i>Жилийн эцэс:</i> Сав газрын УННМТ-ний хэрэгжилтийг эрчимжүүлэх, сав газрын захиргаадын үйл ажиллагааг бэхжүүлэх,</p>	<p>Улсын УННМТ-ний төслийг 4 стратеги зорилгын хүрээнд 19 зорилт, 78 арга хэмжээ 2030 он хүртэл хэрэгжүүлэхээр төлөвлөн боловсруулж, төслийг БОАЖЯ-ны БНБЗГ-т 2023.02.10-нд цахимаар хүргүүлсэн.</p> <p>Төлөвлөгөө боловсруулахад талуудын оролцоог хангах хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан. Анхны цуврал хэлэлцүүлгийг үйл ажиллагаанд тусгах ажил, саналуудыг цуглуулах зорилгоор 12 удаагийн уулзалтуудыг хийж 500 гаруй санал авч холбогдох санал, зөвлөмжийг тусгасан болно.</p> <p>МУ-ын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлж,</p>	100 хувь

				<p>талуудын оролцоог хангах чиглэлээр 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна.</p>	<p>баталуулахаар төлөвлөсөн боловч Монгол Улсын Их Хурлаас 2020 онд шинэчлэн баталсан Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийг баталсны дараа батлах зүйтэй гэж үзсэн.</p> <p>Нэгдсэн Үндэстний байгууллагын Тогтвортой хөгжлийн газар, ЮНЕСКО-ын Усны аюулгүй байдал, тогтвортой менежментийн Олон Улсын төв, БНСУ-ын “K-Water” байгууллагын дэмжлэгтэйгээр “Усны нөөцийн нэгдсэн менежмент” сэдэвт сургалтад БОАЖЯ, 21 СГЗ, Усны газраас холбогдох мэргэжилтнүүд оролцож БНСУ-ын Усны нөөцийн нэгдсэн менежментийн хэрэгжилт, усны нөөц, ашиглалт, усны барилга байгууламжуудын үйл ажиллагаатай танилцаж туршлага судалсан. Мөн Нэгдсэн Үндэстний байгууллагын Тогтвортой хөгжлийн газар болон түншлэгч байгууллагуудтай газрын доорх усны хяналт-шинжилгээг өргөжүүлэх, мэдээлэл болосвруулалтыг сайжруулах, гадаргын усыг хуримтлуулах төсөл хэрэгжүүлэх, салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадваржуулах чиглэлээр хамтран хэрэгжүүлэх, цаашид хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал дэвшүүлсэн.</p>
--	--	--	--	--	---

5.2	<p>Арга хэмжээ 5.2.1</p> <p>Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахад мэргэжил арга зүйгээр хангах, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих</p>	Төсөл хөтөлбөр	Шинэчлэн боловсруулсан сав газрын УННМТ-ний төсөл	Шинэчлэн боловсруулсан сав газрын УННМТ-ний төсөл-3	<p><i>Эхний хагас жил:</i> 2-оос доошгүй сав газрын УННМ-ийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахад мэргэжил, аргазүйн зөвлөмж өгөх;</p> <p><i>Жилийн эцэс:</i> 29 сав газрын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, 3-аас доошгүй сав газрын УННМ-ийн төлөвлөгөөний төслийг батлуулахаар БОАЖЯ-нд хүргүүлсэн байна.</p>	<p>“Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төслийн захиалгаар Ховд, Завхан аймгийн газар нутагт хамаарах Хүйсийн говь-Цэцэг нуур, Увс нуур-Тэс гол, Булган голын сав газар, Дорнод, Сүхбаатар аймгийн газар нутагт хамаарах Хэрлэн, Мэнэнгийн тал, Галба-Өөш, Долоодын говь, Умард говийн гүвээт-Халхын дундад тал, Онон голын сав газрын УННМ-ийн төлөвлөгөөг уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдалтай уялдуулан шинэчлэн боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг “Престиж инженеринг” ХХК гүйцэтгэсэн. Гүйцэтгэгч байгууллагаас ажлын явц, үр дүнг танилцуулах зорилгоор 2023.03.23-ны өдөр зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцож, санал, зөвлөмж өгч ажилласан. Үр дүнгийн тайлангуудыг 2023.11.08-ны өдөр хүлээн авсан. Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2020 оны А/42 тоот тушаалаар баталсан Усны сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачилсан зааврыг шинэчлэн боловсруулсан төсөлд хяналт-шинжлгээ, үнэлгээг сайжруулах асуудлаар зөвлөмж өгч ажилласан.</p>	100 хувь
-----	--	----------------	---	---	--	---	----------

6.	<p>Зорилт 6. Усны нөөцийг бохирдол хомстохоос хамгаалах, нөхөн сэргээх;</p>	Улсын болон орон нутгийн төсөл, төсөл хөтөлбөр	<p>Гол, мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах үндэслэл</p> <p>Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тогтоох чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ;</p>	<p>Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах үндэслэл - 2</p> <p>Улсын хэмжээнд нийт 16 аймагт Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тогтоож, ИТХ-аар батлуулсан.</p>	<p>Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах үндэслэл - 2</p> <p>Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тогтоох чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний тайлан -5</p>	<p>Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан талбай - 119,422.4 га;</p> <p>Усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрүүдийн хамгаалалтын бүс тогтоосон аймгийн тоо – 1;</p> <p>Усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрүүдийн хамгаалалтын бүсийн дэглэмийн хэрэгжилтийн хангах тухай зорилгоор хэрэгжүүлсэн үйл ажиллагаа -2</p>	100 хувь
6.1.	<p>Арга хэмжээ 6.1.1 Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах үндэслэл боловсруулахад СГЗ-дад дэмжлэг үзүүлэх;</p>	Орон нутаг Бусад	Гол, мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах үндэслэл	Гол, мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах үндэслэл- 2	<p><i>Эхний хагас жил:</i> Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах асуудлаар сав газрын захиргаадыг мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна.</p> <p><i>Жилийн эцэс:</i> Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын болон орон нутгийн тусгай</p>	<p>Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах үндэслэл боловсруулах, хамгаалалтад авах ажлыг зохион байгуулах чиглэлээр СГЗ-дад мэргэжил, аргазүйн зөвлөгөө өгч ажилласан. Тайлант хугацаанд Хэрлэн голын сав газрын захиргаанаас Хэрлэн голын томоохон цутгал гол болох Тэнүүний голын 72,451.1 га талбай болон Онон голын цутгал гол болох Бархын голын 46,971.3 га талбайг хамгаалалтад авах ажлыг Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/59 тоот захирамжаар</p>	100 хувь

					хамгаалалтад авах 2-оос доошгүй үндэслэл боловсруулахад мэргэжил арга зүйгээр хангасан байна.	байгуулагдсан ажлын хэсэг тус сумын Баянзүрх багийн хуралд 2023.05.18, Хэнтий багийн хуралд 2023.05.26-нд тус тус оролцож Орон нутгийн хамгаалалтад авах үндэслэл, ач холбогдол болон хамгаалалтын газарт хэрэгжүүлэх дэглэмийг Иргэдийн Нийтийн Хуралд танилцуулж хуралд оролцсон иргэдийн 100% саналаар орон нутгийн хамгаалалтад авахаар шийдвэрлэсэн.	
6.2	<p>Арга хэмжээ 6.2.1</p> <p>Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрт хамгаалалтын бүс тогтоох, дэглэм мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;</p>	Төсөв шаардахгүй	Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тогтоох, дэглэмийг мөрдүүлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ	Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тогтоох, дэглэмийг мөрдүүлэх чиглэлээр Увс, Сүхбаатар аймгийн нийт 20 ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбайд ажилласан.	<p><i>Эхний хагас жил:</i> Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрт хамгаалалтын бүс тогтоох, дэглэмийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 2-оос доошгүй арга хэмжээг зохион байгуулсан байна.</p> <p><i>Жилийн эцэс:</i> Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрт хамгаалалтын бүс тогтоох, дэглэмийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 5-аас доошгүй арга хэмжээг зохион байгуулсан байна.</p>	<p>Усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын бүс тогтоох чиглэлээр СГЗ-дад мэргэжил, аргазүйн зөвлөгөө өгч ажилласан бөгөөд дараах ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд:</p> <p>1. Сүхбаатар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023.03.31 өдрийн 02 дугаар тогтоолоор аймгийн нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын 50,262.52 га талбай, энгийн хамгаалалтын 29,741.72 га талбайд хамгаалалтын бүсийг тогтоосон.</p> <p>2. Сүхбаатар аймгийн Эрдэнцагаан сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй “Монгол ураниум ресурс” ХХК-ийн MV-021459 ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд давхцалтай байгаа усны сан бүхий газрууд болон бэлчээр усжуулалтын зориулалтаар ашиглаж байгаа худгуудад</p>	100 хувь

						<p>хэмжилт хийх, хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх асуудлаар зөвлөмж өгөх, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг Усны газрын даргын 2023.04.26-ны өдрийн А/33 дугаар тушаалаар байгуулж, 2023.04.08-10-ны өдрүүдэд газар дээр нь ажилласан.</p> <p>3. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутаг дахь Могойн голын нүүрсний уурхайн асуудлаар сум, орон нутгийн удирдлага, иргэдийн төлөөлөлтэй уулзаж уурхайн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж ажилласан.</p> <p>4. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн мэдээллийг Газрын нэгдмэл мэдээллийн санд оруулж, салбар дундын мэдээллийн санг бүрдүүлсэн.</p>	
7	<p>Зорилт 7. Усны хяналт-шинжилгээний улсын нэгдсэн сүлжээний байнгын тасралтгүй ажиллагааг хангаж, усны нөөц, горим, чанарт өөрчлөлтөд хяналт тавих, үнэлгээ өгөх</p>	Хувийн хөрөнгө	<p>Улсын усны нэгдсэн хяналт-шинжилгээний сүлжээний үйл ажиллагаа</p> <p>Шинээр холбосон хяналтын цэгийн тоо</p>	<p>Усны хяналт шинжилгээний нэгдсэн сүлжээний портал</p> <p>Шинээр холбосон хяналтын цэгийн тоо -319</p>	<p>Улсын усны нэгдсэн хяналт-шинжилгээний сүлжээний нэгдсэн портал www.groundwater.mn хэвийн ажиллагааг хангасан байна.</p> <p>Хяналт-шинжилгээний</p>	<p>Улсын усны нэгдсэн сүлжээнд холбогдсон цэгүүдэд суурилуулсан хэмжилтийн багаж, төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хянах, гэмтэл, засварын тайлан – 1;</p> <p>Нэгдсэн сүлжээг өргөжүүлэх хяналтын цэгийн тоо – 10;</p>	100 хувь

					цэгийн тоог 323 хүргэсэн байна.		
7.1	<p>Арга хэмжээ 7.1.1</p> <p>Усны хяналт-шинжилгээний улсын нэгдсэн сүлжээнд холбогдсон цэгүүдийн хэмжилтийн мэдээлэлд боловсруулалт хийх, улсын усны мэдээллийн санд хүлээлгэн өгөх</p>	Төсөв шаардахгүй	<p>Нэгдсэн сүлжээнд холбогдсон, хэмжилтийн цэгүүдийн тоо</p> <p>Усны хяналт-шинжилгээний дүн мэдээлэл</p>	Усны хяналт шинжилгээний нэгдсэн сүлжээний портал	<p>Эхний хагас жил: Улсын усны нэгдсэн сүлжээнд холбогдсон цэгүүдэд суурилуулсан хэмжилтийн багаж, төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хянах, гэмтэл, засварын тайланг нэгтгэн гаргасан байна.</p> <p>Жилийн эцэс: Сав газрын захиргаад болон ус ашиглагч байгууллагуудын хяналтын цэгүүдийн хэмжилтийн мэдээлэл боловсруулалтад хяналт тавьж, мэргэжил аргагүйн зөвлөмжөөр хангасан байна.</p>	Улсын усны нэгдсэн сүлжээнд холбогдсон цэгүүдэд суурилуулсан хэмжилтийн багаж, төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хянах, гэмтэл, засварын тайланг нэгтгэн гаргахад Нэгдсэн сүлжээнд 319 цэг холбогдсон байгаагаас DXT зай, Кабель, TD логгер, Gate-S, СИМ карт солих шаардлагатай 126 цэг байна. Иймд нэгдсэн сүлжээний үйл ажиллагааг хэвийн ханган ажиллах зорилгоор 2024 онд Монголын Мянганы сорилтын сангийн дэмжлэгтэйгээр Туул голын сав газрын захиргааны харьяанд байгаа 87 цэгийн тоног төхөөрөмжийг шинэчлэн засварлаж, сүлжээнд холбох ажлыг гүйцэтгэхээр шийдвэрлэсэн.	100 хувь
7.2	<p>Арга хэмжээ 7.2.1</p> <p>Газрын доорх усны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлэх</p>	Хувийн хөрөнгө	Усны хяналт-шинжилгээний улсын нэгдсэн сүлжээнд холбосон ус ашиглагч байгууллагын дотоодын хяналтын цэг	Газрын доорх усны хяналт шинжилгээний 319 цэгийн мэдээллийг www.groundwater.mn нэгдсэн сүлжээнд холбогдсон.	<p>Эхний хагас жил: Усны хяналт-шинжилгээний улсын нэгдсэн сүлжээнд ус ашиглагч байгууллагын 2-оос доошгүй дотоодын хяналтын цэгийг холбосон байна.</p>	Монгол орны усны нөөц, горим, чанарын төлөв байдал, өөрчлөлтөд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, мэдээллээр хангах зорилго бүхий усны хяналт-шинжилгээний нэгдсэн сүлжээг зохион байгуулж азрын доорх усны хяналт шинжилгээний 319 цэгийн мэдээллийг www.groundwater.mn нэгдсэн сүлжээнд холбогдсон. 2023 онд Улсын усны нэгдсэн	100 хувь

					Жилийн эцэс: Усны хяналт-шинжилгээний улсын нэгдсэн сүлжээнд ус ашиглагч байгууллагын 4-өөс доошгүй дотоодын хяналтын цэгийг холбосон байна.	сүлжээг өргөжүүлэх ажилд төсөв батлагдаагүй бөгөөд ус ашиглагч байгууллагуудын дотоодын хяналтын 4-өөс доошгүй цэгээр нэмэгдүүлэхээр төлөвлөсөн. Тус ажлын хүрээнд ус ашиглагч 10 аж ахуйн нэгж байгууллагад дотоодын хяналтын цэг байгуулж, сүлжээнд холбох тухай зөвлөмж хүргүүлсэн бөгөөд 2023.11 сарын байдлаар 4 цэгийг шинээр холбож, нийт хяналт шинжилгээний сүлжээнд 325 цэг холбосон.	
ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ							
Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Усны нөөц, түүнийг зохистой ашиглах усны талаарх хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйгээр хангах							
<i>Усны тухай хуулийн 28.4, 28.7, 16¹.4.9, 16¹.4.10, Агентлагийн үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн 2.5.2.1, 2.5.6.4.</i>							
8	Зорилт 8. Ус ашиглалтыг зохицуулах, хяналт тавих, ус ашиглалтын мэдээллийг улсын хэмжээнд нэгтгэн гаргах	Төсөв шаардахгүй	Дүгнэлтийн тоо Хянасан гэрээ, зөвшөөрлийн тоо Ус ашиглалтын мэдээ, тайлан	Улсын хэмжээнд дунджаар жилд 560-590 сая м ³ ус ашиглаж байна. Ус ашиглалтын мэдээ тайлан 100% нэгтгэгдсэн.	Монгол орны тухайн жилийн ус ашиглалтын мэдээллийг улсын хэмжээнд нэгтгэн гаргасан байна.	2023 оны жилийн эцсийн байдлаар УАХ-ээс гаргасан ус ашиглуулах дүгнэлтийн мэдээллийг 29 сав газрын захиргаа, 21 аймаг, нийслэлээр нь нэгтгэн гаргасан.	100 хувь
8.1	Арга хэмжээ 8.1.1 Хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн ус хангагч байгууллагад ус ашиглуулах дүгнэлт гаргах	Төсөв шаардахгүй	Дүгнэлтийн тоо	2022 онд 28 усаар хангагч байгууллагад дүгнэлт гаргасан.	Усаар хангагч байгууллагуудад дүгнэлт гаргаж, ус ашиглалтын мэдээллийг нэгтгэн боловсруулж, тайлагнасан байна.	Усаар хангагч байгууллагуудаас 2021, 2022, 2023 онд гаргасан ус ашиглуулах дүгнэлтийн мэдээллийг нэгтгэсэн. 2023 онд усаар хангагч 33 аж ахуйн нэгжид ус ашиглуулах дүгнэлт гаргасан. Ус ашиглуулах дүгнэлтээр урьдчилсан	100 хувь

						<p>байдлаар ногдуулсан усны хэмжээ 129.8 сая.м³/жил, усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ 1.05 тэрбум төгрөг.</p> <p>2023 онд Ус ашиглалтын хэлтсээс усаар хангагч 33 аж ахуйн нэгжид ус ашиглуулах дүгнэлт гаргасан.</p>	
8.2	<p>Арга хэмжээ 8.2.1</p> <p>Хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлт гаргах</p>	Төсөв шаардахгүй	Дүгнэлтийн тоо	2022 онд 209 аж ахуйн нэгжид ус ашиглуулах дүгнэлт гаргасан.	<p>Ус ашиглуулах дүгнэлтийг хууль дүрэм журамд нийцүүлэн хуулийн хугацаанд нь гаргаж, ус ашиглалтын мэдээллийг хагас жилийн байдлаар нэгтгэн гаргасан байна.</p>	<p>2023 оны ус ашиглуулах дүгнэлтийн мэдээллийг 21 сав газрын захиргаа, аймаг, нийслэлээр мэдээг эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар нэгтгэн гаргасан.</p> <p>2023 оны жилийн эцсийн байдлаар хөдөө аж ахуйн салбарт 1.7 сая м.куб, уул уурхайн салбарт 122 сая м.куб, хүнд үйлдвэрт 0.2 сая м.куб, эрчим хүчний үйлдвэрлэлийн салбарт 36,3 сая м.куб, хүнсний үйлдвэрийн салбарт 4.8 сая м.куб, барилга, барилгын материал үйлдвэрлэлийн салбарт 2.9 сая м.куб, зам засварын салбарт 0.7 сая м.куб, аялал жуулчлалын салбарт 0.05 сая м.куб, ахуйн үйлчилгээний салбарт 0.8 сая м.куб ус ашиглахаар байна.</p> <p>2023.12.04-ний байдлаар 209 аж ахуй нэгж, байгууллагын ус ашиглуулах дүгнэлтийг гаргаж, мэдээллийг салбараар, сав газрын захиргаа, аймаг, нийслэлээр нэгтгэн гаргасан.</p> <p>Ус ашиглуулах дүгнэлтээр урьдчилсан байдлаар төлбөр ногдуулсан усны хэмжээ 172.0</p>	100 хувь

						<p>сая.м³/жил, усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ 121.6 тэрбум төгрөг.</p> <p>Ус ашиглуулах дүгнэлт гаргуулсны үйлчилгээний хөлсөнд 1.2 тэрбум төгрөгийг нэхэмжлэн Төрийн санд төвлөрүүлсэн.</p>	
8.3	<p>Арга хэмжээ 8.3.1</p> <p>Ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээнд хяналт тавих</p>	Төсөв шаардахгүй	Зөвлөмжийн тоо	2022 онд 108 зөвшөөрөл, 121 гэрээг хянаж, 10 СГЗ-нд санал зөвлөмж хүргүүлсэн.	СГЗ болон аймаг, нийслэлийн БОАЖГ-т с анал, дүгнэлт, зөвлөмж 20-аас доошгүйг хүргүүлсэн байна.	<p>29 сав газрын захиргаад болон 21 аймаг, нийслэлийн БОАЖГ-даас 29 сав газрын захиргаад болон 21 аймаг, нийслэлийн БОАЖГ-даас 2023 онд гаргасан 294 ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээнд хяналт тавин, зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>СГЗ-ны ногдуулсан усны хэмжээ 10,360,150.4м.куб/жил, БОАЖГ-ын усны хэмжээ, 1,680,279.5 м.куб/жил, урьдчилсан байдлаар 304.4 сая төгрөг ноогдуулсан.</p>	100 хувь
8.4	<p>Арга хэмжээ 8.4.1</p> <p>Голын голдирлыг өөрчлөх, урсцад тохируулга хийх, шилжүүлэн ашиглах, усны барилга байгууламж барих, усны сан бүхий газрын ашиглалтын төсөлд дүгнэлт гаргах</p>	Төсөв шаардахгүй	Ирүүлсэн хүсэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн байдал	Усны барилга байгууламжийн зураг төсөлд 10 дүгнэлт гаргасан.	Усны барилга байгууламжийн зураг төсөл хийлгэхээр ирүүлсэн хүсэлтийг хуулийн хүрээнд шийдвэрлэж дүгнэлт гаргасан байна. Төслүүдийн талаарх нэгдсэн танилцуулга-1	<p>2023 оны жилийн эцсийн байдлаар голын голдирлыг өөрчлөхөөр зураг төслөө ирүүлсэн 1 компанид, усны барилга байгууламжийн зураг төсөлд дүгнэлт гаргуулахаар хүсэлт ирүүлсэн 18 компанид дүгнэлт гаргаж хүргүүлсэн.</p>	100 хувь
<p>Стратеги төлөвлөгөөний зорилго 2. Усны нөөцийг бохирдол, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, цэвэрлэсэн болон саарал усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах</p>							
<p><i>Усны тухай хуулийн 7.4, 16'1.3, 16'4.5, 16'4.6, 16'4.8, 24.2, 24.5, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 5, 6 дугаар зүйл. Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн зорилт 2.5.3.1, 2.5.3.2, 2.5.3.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны "Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ" тогтоосон 316 дугаар тогтоол.</i></p>							

9	Зорилт 9. Усны мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, баяжуулах, мэдээллээр хангах	Төсөв шаардахгүй	Тайлан мэдээ, мэдээллийн санг баяжуулсан байдал	Шинээр хийгдэнэ.	Хаягдал усны талаарх мэдээллийг 100 хувь нэгтгэж, тооцоо, судалгааны тайлан мэдээллийн чанарыг сайжруулсан байна.	Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан.	100 хувь
9.1	Арга хэмжээ 9.1.1 Хоногт 50 шоо метрээс их эсхүл аюултай бохирдуулах бодис бүхий хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид хаягдал усны дүгнэлт гаргах	Төсөв шаардахгүй	Дүгнэлт гаргасан байдал Нэгтгэсэн мэдээ, тайлангийн чанар	Усны газар 2022 онд 120 ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хаягдал усны дүгнэлтийг гаргасан. Жил бүр хийгдэнэ.	<i>Эхний хагас жил:</i> Хаягдал усны 60 ААНБ-ын дүгнэлтийг гаргаж, хуулийн хэрэгжилтийг сайжруулж, мэдээллийг тайлагнана. <i>Жилийн эцэс:</i> Хаягдал усны 120 ААНБ-ын дүгнэлтийг хугацаанд нь гаргаж, судалгааг сав газар, салбараар нэгтгэн гаргасан байна.	Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ус бохирдуулагч 170 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хаягдал усны дүгнэлт гаргаж, удирдлага, арга зүйгээр ханган ажилласан бөгөөд өмнөх жилийн гүйцэтгэлээс 1.36 дахин давуулан биелүүлсэн. Мөн энэ ажлын хүрээнд 2022 онд ус ашиглуулах дүгнэлт гаргуулсан ч хаягдал усны дүгнэлт гаргуулаагүй 89 аж ахуйн нэгж байгууллагад Усны газраас 2023 оны 01/1009 тоот “Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай” мэдэгдэл хүргүүлж, 30 хуулийн этгээд 2020, 2021, 2022 оны хаягдал усны дүгнэлтээ нөхөж гаргуулаад байна.	100 хувь
9.2	Арга хэмжээ 9.2.1 Хоногт 50 шоо метрээс их эсхүл аюултай бохирдуулах бодис бүхий хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчдын ус бохидуулсны төлбөрийг тооцож, Татварын албанд хүргүүлэх, хаягдал усны чанарын	Төсөв шаардахгүй	Төлбөр тооцсон байдал Нэгтгэсэн мэдээ, тайлангийн чанар	Усны газар 2022 онд 120 ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын ус	<i>Эхний хагас жил:</i> Хоногт 50 шоо метрээс их эсхүл аюултай бохирдуулах бодис бүхий хаягдал ус гаргадаг үйлдвэрлэл,	Ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 2023 онд 8.87 тэрбум төгрөгийн төлбөр, 1.07 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр тус тус ногдуулж, мэдээллийг харьяалах татварын алба, салбарын хяналтын газарт хүргүүлж ажилласан.	100 хувь

	<p>стандартаас хэтрүүлэн гаргасан бодис тус бүрт ус бохирдуулсны нөхөн төлбөр тооцон, Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлэх</p>			<p>бохирдуулсны төлбөрийг тооцсон. СГЗ-ны 2022 онд тооцсон 3518 ус бохирдуулагчдын ус бохирдуулсны төлбөрийн тооцоог хянасан.</p>	<p>үйлчилгээ эрхлэгчдийн 2022 оны IV улирал, 2023 оны I улирлын ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөрийг тооцон, Татварын алба, Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлж, мэдээллийг тайлагнасан байна. СГЗ-аас ирүүлсэн хоногт 50 шоо метрээс бага хаягдал ус гаргадаг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн 2022 оны ус бохирдуулсны төлбөрийн тооцоог хянаж, нэгтгэн Татварын албанд хүргүүлж мэдээллийг тайлагнасан байна. <i>Жилийн эцэс:</i> Хоногт 50 шоо метрээс их эсхүл аюултай бохирдуулах бодис бүхий хаягдал ус гаргадаг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн 2023 оны II, III улирлын ус бохирдуулсны</p>	<p>Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд нийт 5.0 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлсэн. Үүнээс 2020 онд 46.3 сая төгрөг, 2021 онд 478.7 сая төгрөг, 2022 онд 2.34 тэрбум төгрөг, 2023-ны байдлаар 2.12 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна.</p>	
--	--	--	--	---	--	--	--

					төлбөр, нөхөн төлбөрийг тооцон Татварын алба, Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлж, мэдээллийг тайлагнасан байна.		
9.3	<p>Арга хэмжээ 9.3.1 Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичгийг хуваарилах, олгосон зөвшөөрөлд хяналт тавих, дүнг нэгтгэх, бүртгэлжүүлэх</p>	Төсөв шаардахгүй	СГЗ, аймаг, нийслэлийн БОАЖГ-т хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичгийг шаардлагатай хэмжээгээр хүргүүлж, бүртгэлжүүлсэн байх	СГЗ, аймаг, нийслэлийн БОАЖГ-т хаягдал ус хаях зайлуулах зөвшөөрлийн бичиг /200 ш/-ийг хүргүүлсэн.	<p><i>Эхний хагас жил:</i> Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичгийг тухайн жилд шаардлагатай хэмжээгээр хүргүүлж ажилласан байна.</p> <p><i>Жилийн эцэс:</i> Зөвшөөрлийн бичгийг олгох үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан байна.</p>	Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичгийг олгох ажилд хяналт тавьж, олгосон зөвшөөрлийн бичгийн тоон мэдээг Улсын хэмжээнд нэгтгэж ажиллав. Үүнд: 21 СГЗ-170 ш, 241 сумын Засаг дарга 3868 зөвшөөрлийн бичиг олгосон байна.	100 хувь
9.4	<p>Арга хэмжээ 9.4.1 “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-нд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх, биелэлтийг холбогдох газарт хүргүүлэх;</p>	Засгийн газрын 2020 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан төсвөөр	Ажлын хэсэгт шаардлагатай мэдээ, материалыг гаргаж, тайланг цаг тухайд нь хүргүүлсэн байна. /нийт 4 удаа/	ҮХУУЦТ-ний хэрэгжилтийг хангаж, Усны газраас хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг холбогдох газарт /4 удаа/ хүргүүлсэн байна.	<p><i>Эхний хагас жил:</i> ҮХУУЦТ-нд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх, холбогдох тайлан, мэдээг гаргаж ММСС-тай хамтран ажилласан байна.</p> <p><i>Жилийн эцэс:</i> ҮХУУЦТ-ний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах</p>	1. Барилга, хот байгуулалтын яамны дэд сайд Э.Золбоогоор ахлуулсан “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлын хэсгийн Усны газрын хариуцаж гүйцэтгэх үүрэг бүхий 9 ажлын хэрэгжилтийн төлөвлөгөө, тайланг улирал, жилээр тус тус гарган БХБЯ-ны Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн хэлтэст хүргүүлж ажилласан.	100 хувь

				<p>чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн хурлуудад оролцож, Усны газраас хийж хэрэгжүүлж буй ажлын тайланг улирал бүр /4 удаа/ хүргүүлж ажилласан байна.</p>	<p>2.“Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламжийн технологийн заавар, гарын авлага боловсруулах олон улсын зөвлөх үйлчилгээний “JV Segeusa” болон “Еврохан” ХХК-тай хамтран ажиллаж, Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS6561:2015 стандартын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын хурлын танхимд 2023.09.27, 2020.10.3, 10-ны өдрүүдэд арьс шир, ноос ноолуурын үйлдвэрүүд, хүнсний үйлдвэр /архи, спирт, пиво, ус, ундаа, сүү, сүүн бүтээгдэхүүн, мах махан бүтээгдэхүүний/-үүд, машин угаалга, хивс угаалга, хими цэвэрлэгээ, нийтийн хоолны салбараар тус тус стандартын төсөл, гарын авлагыг танилцуулах сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.</p> <p>Мөн энэхүү стандартыг боловсруулах ажлын хүрээнд суурь судалгаа хийх зорилгоор ММСС болон УСУГ, Туул голын СГЗ, ЭМЯ, БХТөв, ХСУХАТАҮЗХороотой хамтран Нийслэлийн томоохон бохирдуулагч 70 үйлдвэрүүдэд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.</p>	
--	--	--	--	--	--	--

						3. Усны газар, ММСС-тай хамтран хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийг хурдан, үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор талуудын саналыг үндэслэн 24 удаагийн хурал, семинар, уулзалтуудыг зохион байгуулж ажилласан байна.	
10	Зорилт 10. Ус бохирдуулсны төлбөр, зөвшөөрөл олгох үйл явцаар дамжуулан үйлдвэрлэлийн усны дахин усны дахин ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлж, хаягдал ус дахин боловсруулах, цэвэрлэсэн усыг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.	Төсөв шаардахгүй	Зохион байгуулсан сургалт, оролцогчдын тоо Суурилуулсан тоолуурын тоо Дүгнэлт гаргасан байдал, мэдээ тайлан	2022 онд 20 удаа сургалтыг зохион байгуулсан. Шинээр хийгдэнэ.	Тухайн жилийн хаягдал усны талаарх мэдээллийг 100 хувь нэгтгэж, тооцоо, судалгааны тайлан мэдээллийн чанарыг сайжруулсан байна.	Зохион байгуулсан сургалт-18, оролцогчдын тоо-684 Дүгнэлт гаргасан байдал, мэдээ тайлан- өмнөх онд 124, тайлант онд 170 дүгнэлт буюу 136 % үр дүнтэй.	100 хувь
10.1	Арга хэмжээ 10.1.1 Усны тухай, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх, дагалдан гарсан дүрэм, журам, бусад эрхзүйн актуудыг олон нийтэд сурталчлан танилцуулах, түгээн дэлгэрүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах.	Төсөв шаардахгүй	Мэдээ, мэдээллийг бэлтгэх, Зохион байгуулсан сургалт, оролцогчдын тоо	2022 онд 20 удаа сургалтыг зохион байгуулсан.	<i>Эхний хагас жил:</i> Усны тухай, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт, дүрэм, журмыг сурталчлан таниулах сургалтыг 10 удаа зохион байгуулсан байна. <i>Жилийн эцэс:</i> Усны тухай, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт, дүрэм, журмыг сурталчлан таниулах	Усны тухай, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх, дагалдан гарсан дүрэм, журам, бусад эрхзүйн актуудыг олон нийтэд сурталчлан танилцуулах, түгээн дэлгэрүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах зорилгоор нийт 18 удаагийн сургалтыг зохион байгуулж, төрийн болон хувийн хэвшлийн 684 ажилтан, албан хаагчийг хамруулсан. Үүнд: Ус Үндэсний чуулганы 3-р салбар хуралдаан, БОАЖЯам, БХБЯ, ШУА-ийн Техник технологийн салбар, Хот суурины ус хангамж ариутгах	100 хувь

					сургалтыг 10 удаа зохион байгуулсан байна.	татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл, НБОГ, Дархан-Уул, Сүхбаатар, Орхон, Булган, Баянхонгор, Дорноговь аймгийн Татварын хэлтэс, БОАЖГ, Сэлэнгэ, Орхон-Чулуут, Хануй, Хараа-Ерөө, голын СГЗ, Бөөнцагаан-Орог нуурын СГЗ, Хяргас нуур-Завхан голын СГЗ, ЦУОШТөв, Хот, суурин газрын цэвэрлэх байгууламжийн ашиглалт, үйлчилгээ хариуцсан байгууллагууд, Эрдэнэтийн ДЦС, Дарханы ДЦС ТӨХК, Уул уурхайн олборлох, баяжуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй томоохон аж ахуйн нэгж байгууллагууд зэрэг болно.	
10.2	<p>Арга хэмжээ 10.2.1</p> <p>Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах болон түүнтэй дагалдан Усны тухай, Төсвийн тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд холбогдох нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг удирдлагаар хангах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллах;</p>	Төсөв шаардахгүй	Зөвлөх үйлчилгээний багийг мэдээллээр хангаж ажилласан байх	Шинээр хийгдэнэ.	<p><i>Эхний хагас, Жилийн эцэс:</i></p> <p>Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, холбогдох эрх зүйн актуудад нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгийг мэдээллээр хангаж ажилласан байна.</p>	<p>БОАЖ-ын Сайдын 2022 оны А/581 дүгээр тушаалаар баталсан Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгийн хүрээнд хуулийн төслийг боловсруулж, салбарын төрийн, төрийн бус байгууллагууд, ус бохирдуулагч аж ахуйн нэгж байгууллагууд болон эрх ашиг нь хөндөгдөхүйц талуудыг хамруулан 5 удаагийн танхимын уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, ХХААХҮЯам, БХБЯам, ХЗЯ-нд төслийг хүргүүлж, тус бүрийн саналыг харгалзан тусгаж, хуулийн үзэл баримтлалыг боловсруулан БОХХААБХорооны “Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах” дэд ажлын хэсэгт эцсийн</p>	100 хувь

						байдлаар хүргүүлэв. Мөн Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг БОАЖЯ-ны цахим сайтад байршуулж, олон нийтийн санал авч байна.	
10.3	<p>Арга хэмжээ 10.3.1 СГЗ-дын ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулсан талаарх мэдээллийг нэгтгэж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах;</p>	Төсөв шаардахгүй	<p>Төлбөрийн гэрээнд хяналт тавьсан байдал, төлбөрийн гэрээний тоо</p> <p>Нэгтгэсэн мэдээ, тайлангийн чанар</p>	Сав газрын захиргаад 2022 онд 110 төлбөрийн гэрээг байгуулсан байна.	<p><i>Эхний хагас жил:</i> Хаягдал усаа байгальд шууд нийлүүлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай сав газрын захиргааны байгуулсан 2023 оны ус бохирдуулсны төлбөрийн гэрээ, гэрээ дүгнэсэн байдалд хяналт тавьж ажиллах, мэдээллийг нэгтгэж ажилласан байна.</p> <p><i>Жилийн эцэс:</i> Хаягдал усаа байгальд шууд нийлүүлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай СГЗ-ны байгуулсан 2023 оны ус бохирдуулсны төлбөрийн гэрээ, гэрээ дүгнэсэн байдалд хяналт</p>	Улсын хэмжээнд 126 ус бохирдуулагч аж ахуйн нэгж байгууллагатай 170 дүгнэлтээр тооцож, ногдуулсан 2.1 тэрбум төгрөгийн “Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ” байгуулж ажилласан байна.	100 хувь

					тавьж ажиллах, мэдээллийг нэгтгэж ажилласан байна.			
10.4	Арга хэмжээ 10.4.1 Ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх, урамшууллын механизмыг нэвтрүүлэх;	Төсөв шаардахгүй	Ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх, урамшуулах аж ахуйн нэгж байгууллагаас хөнгөлсөн хаягдал усны хэмжээ, төлбөрийн дүнг нэгтгэж тайлагнасан байх	Жил хийгдэнэ.	бүр	<p>Эхний хагас жил: Ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлсөн, чөлөөлсөн төлбөр, эргүүлэн ашигласан хаягдал усны хэмжээг нэгтгэн боловсруулж, тайлагнасан байна.</p> <p>Жилийн эцэс: Ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлсөн талаарх мэдээллийг нэгтгэн боловсруулж, Улсын усны мэдээллийн санд оруулсан байна.</p>	Усны газар нь Хот, суурин газрын цэвэрлэх байгууламжийн ашиглалт, үйлчилгээ хариуцсан 25 байгууллагын ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд бохир ус нийлүүлж буй төсвөөс санхүүждэг эрүүл мэндийн салбарын 119, боловсролын салбарын 449 байгууллагыг журмын дагуу төлбөрөөс хөнгөлсөн. Ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд бохир ус нийлүүлдэг 5885 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 180.8 сая.төг ногдуулж, 77506 өрхийн 252.2 сая.төгрөгийг журмын дагуу төлбөрөөс чөлөөлсөн. Хаягдал усыг цэвэрлэж, эргүүлэн ашигласан 104 хуулийн этгээдийг /давхардсан тоогоор/ хуулийн дагуу эргүүлэн ашигласан усны хэмжээгээр 4.25 тэрбум төгрөгийг чөлөөлсөн. /эргүүлэн ашигласан усны хэмжээ 119.6 сая.м ³ / 21-н сав газрын захиргаа нь Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт заасны дагуу төсвөөс санхүүждэг эрүүл мэндийн 195 байгууллагын 103.3 сая.төг, боловсролын 440 байгууллагын 51.8 сая.төг, халамжийн 19 байгууллагын 2.9 сая төгрөг тус тус хөнгөлсөн байна.	100 хувь
Стратеги төлөвлөгөөний зорилго 3. Усны нөөцийг судалж тогтоох, усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, нөхөн сэргээх, бохирдохоос урьдчилан сэргийлэх, усны сав газрын менежментийн тогтолцоог бэхжүүлэх								

Усны тухай хуулийн 16'4.1, 16'4.2, 16'4.5, 16'4.6, 16'4.7, 6.1, 6.2, 6.3, 6.4, 10.1.7, "Алсын хараа 2050" урт хугацааны хөгжлийн бодлого зорилт 6.3, "Ус" үндэсний хөтөлбөрийн 2.2.2, 3.2, Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн зорилт 2.5.1.

11	Зорилт 11. Усны тоо бүртгэл, статистик мэдээлэл, кадастр, улсын усны мэдээллийн сан бүрдүүлэх	Төсөв шаардахгүй	Улсын усны мэдээллийн санд оруулсан сав газрын мэдээ бүрдүүлэлтийн хувь	2021 оны усны тоо бүртгэл, мэдээ мэдээлэл. 2021 оны БОХ 2.1, БОХ 2.2 маягтыг хуулийн хугацаанд хянасан.	Мэдээллийн санд оруулсан дүн мэдээллүүдийг хянан шалгаж, 2022 оны усны тоо бүртгэлийн мэдээ тайланг нэгтгэн боловсруулж, мэдээллийн санд оруулсан байна. 2022 оны БОХ 2.1, БОХ 2.2 маягтыг хуулийн хугацаанд хянасан байна.	2022 онд БОХ 2.1, БОХ 2.2 маягтын мэдээлэл бүрдүүлэлт 2022 оны усны тоо бүртгэлийн тайлан	
11.1	Арга хэмжээ 11.1.1 Улсын усны мэдээллийн санд eic.mn-д сав газрын захиргаадын мэдээллийг төвлөрүүлэх	Төсөв шаардахгүй	Улсын усны мэдээллийн сангийн мэдээллийг бүрдэл	Улсын усны мэдээллийн сан 29 сав газрын 2021 оны усны тоо бүртгэл, мэдээ мэдээллүүдийг оруулсан.	Эхний хагас жил: Мэдээллийн санд оруулсан дүн мэдээллүүдийг хянан шалгасан байна. Жилийн эцэс: 2022 оны усны тоо бүртгэлийн мэдээ тайланг нэгтгэн боловсруулж, мэдээллийн санд оруулсан байна.	Байгаль орчны мэдээллийн сан eic.mn цахим хуудасны ус, рашааны мэдээллийн дэд санд сав газрын захиргаадын 2022 оны усны тоо бүртгэлийн тайланг хянаж оруулсан. 21 сав газрын захиргаанаас 2023 оны усны тоо бүртгэлийн тайланг хүлээн авч, тоон мэдээллүүдийг eic.mn -д оруулсан.	100 хувь
11.2	Арга хэмжээ 11.2.1 Аймаг нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас Байгаль орчны мэдээллийн санд БОХ 2.1, БОХ 2.2 маягтын дагуу оруулсан мэдээллийг хяналт, мэргэжил аргазүйн зөвлөмж өгөх;	Төсөв шаардахгүй	Өмнөх оны мэдээллийн зөрүүгийн засвар хийсэн байдал	2021 оны БОХ 2.1, БОХ 2.2 маягтыг хуулийн хугацаанд хянасан.	Эхний хагас жил: Аймаг нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас БОХ 2.1, БОХ 2.2 маягтын дагуу холбогдох мэдээллүүдийг	Байгаль орчны статистик мэдээг БОХ 2.1, БОХ 2.2 маягтын дагуу аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын усны асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж тоон мэдээллийн бүрдүүлэлт хийсэн.	100 хувь

			БОХ 2.1, БОХ 2.2 маягтын дүн мэдээ		хуулийн хугацаанд хянаж, байгаль орчны мэдээллийн санд оруулсан байна. Жилийн эцэс: 2022 оны БОХ 2.1, БОХ 2.2 маягтын дагуу холбогдох мэдээллүүдийг хуулийн хугацаанд хянаж, байгаль орчны мэдээллийн санд оруулсан байна.	2022 оны усны тоо бүртгэлийн нэгдсэн тоо бүртгэлийн мэдээг гаргасан. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Гол горхи-6764 • Нуур тойром-4414 • Булаг шанд-13566 • Хөв цөөрөм-2014 үүнээс ширгэсэн 370, сэргэсэн 314 байна. 2023 онд улсын хэмжээнд 180 булаг шандын эхийг хашиж хамгаалсан байна. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын усны асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж 2023 оны БОХ маягтын тоон мэдээллийг хэрхэн бүрдүүлж, оруулах тухай мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллаж байна. 2023 оны Байгаль орчны статистик мэдээний үр дүнг БОХ 2.1, БОХ 2.2 маягтын дагуу 2024 оны нэгдүгээр улиралд гарна.	
11.3	Арга хэмжээ 11.3.1 Усны мэдээллийн сангийн мэдээлэл бүрдүүлэлтийг хангаж, улсын усны төлөв байдлын тайланг гаргах	Төсөв шаардахгүй	Усны төлөв байдлын тайлан	2021 оны усны төлөв байдлын тайланд холбогдох мэдээллээр хангаж ажилласан.	<i>Эхний хагас жил:</i> Усны мэдээллийн сангийн мэдээлэл бүрдүүлэлтийг хангах, сав газрын мэдээллийн сан хариуцсан мэргэжилтнүүдийг мэргэжил аргазүйн зөвлөмжөөр хангах ажлыг зохион байгуулна. Усны мэдээллийн сангийн мэдээлэл бүрдүүлэлтийг	21 Сав газрын захиргаадын мэдээллийн дэд сан хариуцсан мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Усны мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн Усны төлөв байдлын тайланг нэгтгэн гаргаж, БОАЖЯ-ны БНБЗГ-ын мэргэжилтэн Д.Даваанямд davaanyam2006@gmail.com цахим хаягаар хүргүүлсэн. Тайланд Монгол орны усны нөөц, горим, чанарын төлөв байдал, хайгуул, судалгаа, усны	100 хувь

					хангаж, 2022 оны улсын усны төлөв байдлын тайланг гаргах ажлыг зохион байгуулна.	тоо бүртгэл, газрын доорх усны хяналт шинжилгээний сүлжээ, ус ашиглалт, хаягдал усны тоо хэмжээ, бохирдлын дүн мэдээллүүдийг тусгасан.	
11.4	Арга хэмжээ 11.4.1: Улсын усны мэдээллийн сангийн журмыг шинэчлэн боловсруулах	Төсөл хөтөлбөр	Шинэчлэн боловсруулсан журам	БОАЖС-ын 2014 оны А/86 дугаар тушаалаар баталсан журам	<i>Жилийн эцэс:</i> Шинэчлэн боловсруулсан журмын төсөлд холбогдох байгууллагуудаас санал авч, хэлэлцүүлэн БОАЖЯ-нд хүргүүлсэн байна.	БОАЖС-ын 2014 оны А/86 дугаар тушаалаар баталсан Улсын усны мэдээллийн сангийн журмыг шинэчлэн боловсруулж, журмын төсөлд БХБЯ, УУХҮЯ, ХААХҮЯ, ҮСХ, ЦУОШГ, ГЗБГЗЗГ, Монголын гидрологийн холбоо, Монголын Гидрогеологичдын холбоо, Усжуулагчдын холбоо, ШУТИС, МУИС, ХААИС, аймагт нийслэлийн БОАЖГ, 21 сав газрын захиргаадаас нийт 2 удаа санал авсан. Журмын төсөлд холбогдох санал, зөвлөмжийг тусгаж, 2023.12.05 өдрийн 01/1392 дугаартай албан бичгээр БОАЖС-дад батлуулахаар хүргүүлсэн.	100 хувь
11.5	Арга хэмжээ 11.5.1: Усны тоо бүртгэл явуулах журмыг шинэчлэн боловсруулах	Төсөл хөтөлбөр	Шинэчлэн боловсруулсан журам	БОАЖС-ын 2006 оны А/269 дүгээр тушаалаар баталсан журам	<i>Жилийн эцэс:</i> Шинэчлэн боловсруулсан журмын төсөлд холбогдох байгууллагуудаас санал авч, хэлэлцүүлэн БОАЖЯ-нд хүргүүлсэн байна.	БОАЖС-ын 2006 оны А/269 дүгээр тушаалаар баталсан Усны тоо бүртгэл явуулах журмыг шинэчлэн боловсруулж, журмын төсөлд БХБЯ, УУХҮЯ, ХААХҮЯ, ҮСХ, ЦУОШГ, ГЗБГЗЗГ, Монголын гидрологийн холбоо, Монголын Гидрогеологичдын холбоо, Усжуулагчдын холбоо, ШУТИС, МУИС, ХААИС, аймагт нийслэлийн БОАЖГ, 21 сав газрын захиргаадаас нийт 2 удаа санал авсан. Журмын төсөлд холбогдох санал, зөвлөмжийг тусгаж, 2023.12.05 өдрийн 01/1392 дугаартай албан бичгээр	100 хувь

						БОАЖС-дад батлуулахаар хүргүүлсэн.	
12.	<p>Зорилт 12. Усны ашиглах боломжит нөөцийн хэмжээг сав газрын хэмжээнд ашиглалтын зориулалт бүрээр тогтоон боловсруулж мөрдүүлэх, хяналт тавих</p>	Төсөв шаардахгүй			<p>Усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийн гаргуулсан төслийн тоо -120</p> <p>Газрын доорх ордод нөхөн төлбөрийг тооцсон гэрээ – 3;</p> <p>Усны нөөцөд хохирол учруулсан байж болох аж ахуйн нэгжийн судалгааны тайлан, доошгүй ус ашиглагчийн усны нөөцөд учруулсан хохирлыг тооцоо - 2;</p>	<p>Усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийн гаргуулсан төслийн тоо - 197</p> <p>Газрын доорх ордод нөхөн төлбөрийг тооцсон гэрээ – 4;</p> <p>Усны нөөцөд хохирол учруулсан байж болох аж ахуйн нэгжийн судалгааны тайлан, доошгүй ус ашиглагчийн усны нөөцөд учруулсан хохирлыг тооцоо - 7;</p>	100 хувь
12.1.	<p>Арга хэмжээ 12.1.1 Усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргах;</p>	Төсөв шаардахгүй	Усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийн тоо	2022 онд нийт 322 төслийн ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргасан.	<p><i>Эхний хагас жил:</i> Усны ашиглах боломжит нөөцийн 60 дүгнэлтийг хугацаанд нь гаргаж, ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэсэн байна.</p> <p><i>Жилийн эцэс:</i> Ус боломжит нөөцийн дүгнэлтийг 120-оос доошгүй байгууллагад хугацаанд нь гаргаж, мэдээ</p>	<p>Усны боломжит нөөцийн дүгнэлт гаргуулахаар 227 ААНБ-аас хүсэлт ирүүлснээс газрын доорх усны ордын талбай, усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүстэй давхцалтай 9, дүгнэлт гаргуулахад бүрдүүлэх материал дутуу 8, ус хангамжийн эх үүсвэр шийдвэрлээгүй 5 төсөлд холбогдох хариуг албан бичгээр хүргүүлж, 197 ААНБ-д дүгнэлт гаргасан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Барилга – 12 -Уул уурхай - 72 -Арьс шир боловсруулах – 10 -Хүнсний үйлдвэр – 8 	100 хувь

					тайланг нэгтгэсэн байна.	-Амралт, сувилал, аялал жуулчлал – 40 -Эрчим хүч – 4 -Хөдөө аж ахуй – 2 -Хүнд үйлдвэр – 10 -Нефтийн агуулах – 5 -Бусад – 34.	
12.2	Арга хэмжээ 12.2.1 Улсын төсвийн хөрөнгөөр судалж тогтоосон газрын доорх усны нөөцийн эрэл хайгуул, судалгааны зардлыг ус ашиглагчаар эргүүлэн төлүүлэх журмын дагуу тооцооллыг хянах, гэрээ байгуулах;	Төсөв шаардахгүй	Нөхөн төлбөр тооцож, байгуулсан гэрээний тоо	2022 онд газрын доорх усны 5 ордод нөхөн төлбөр тооцож, гэрээ байгуулсан.	<i>Эхний хагас жил:</i> Газрын доорх усны ордоос ус ашиглагч 1-ээс доошгүй аж ахуйн нэгжид нөхөн төлбөр тооцож, гэрээ байгуулсан байна. <i>Жилийн эцэс:</i> Газрын доорх усны ордоос ус ашиглагч 2-оос доошгүй аж ахуйн нэгжид нөхөн төлбөр тооцож, гэрээ байгуулж, нөхөн төлбөрийн татан төвлөрүүлэлт хийсэн байна.	Улсын төсвийн хөрөнгөөр судалж нөөц тогтоосон газрын доорх усны ордоос ус ашиглаж байгаа 4 аж ахуйн нэгж байгууллагад нөхөн төлбөрийн тооцоо хүргүүлж, гэрээ байгуулан ажилласан. Үүнд: 1. Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутаг дэвсгэрт Улсын төсвийн хөрөнгөөр судалж нөөц тогтоосон “Хэрлэн-Өндөрхаан” газрын доорх усны ордоос ус ашиглаж байгаа “Хан бүргэд Хэрлэн” ХХК-нд Засгийн газрын 2014 оны 12 дугаар тогтоолын дагуу 4,846,417 төгрөгний нөхөн төлбөр тооцон хүргүүлж, 2023.03.30-ны өдрийн 01 тоот гэрээ байгуулсан бөгөөд гэрээний дагуу улсын төсөвт 1,000,000 төгрөгийг төвлөрүүлсэн байна. 2. Баянхонгор аймгийн Галуут сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Монголболгаргео” ХХК нь Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул, судалгаа хийж, нөөц тогтоосон “Сойрын худаг ба Өвөрчулуут, Мухар эрэг”-ийн газрын доорх усны ордоос ус ашиглаж байгаа бөгөөд тухайн компанид 253,490,201 төгрөгийн нөхөн төлбөр тооцон 2023.05.30 өдрийн 01/541 тоот албан	100 хувь

						<p>бичгээр хүргүүлсэн. Мөн 2014 оны нөхөн төлбөр эргүүлэн төлүүлэх гэрээний 2 дугаар хавсралтыг дээрх тоот албан бичгээр:</p> <p>3. Төв аймгийн Аргалант сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Об ойл интастриал” ХХК нь Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул, судалгаа хийж, нөөц тогтоосон “Хүй долоон худаг” газрын доорх усны ордоос ус ашиглах тул 953,577 (Есөн зуун тавин гурван мянга таван зуун далан долоон) төгрөгийн нөхөн төлбөр тооцон 2023.09.08 өдрийн 01/1042 тоот албан бичгээр;</p> <p>4. Нийслэлийн Налайх дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Бласт” ХХК нь “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” газрын доорх усны ордоос ус ашиглах тул 4,446,628 (дөрвөн сая дөрвөн зуун дөчин зургаан мянга зургаан зуун хорин найман) төгрөгийн нөхөн төлбөр тооцон 2023.11.21-ний өдрийн 01/1374 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.</p>	
12.3	<p>Арга хэмжээ 12.3.1</p> <p>Усны нөөцөд учирсан хохирлыг үнэлэх, нөхөн төлбөр тооцох;</p>	Төсөв шаардахгүй	Усны нөөцөд хохирол учирч байгаа эсэхэд хяналт тавьсан ажлын тоо;	2022 онд Усны нөөцөд учирсан хохирлыг 3 аж ахуйн нэгж байгууллагад тооцсон.	<p><i>Эхний хагас жил:</i> Усны нөөцөд хохирол учруулсан байж болох аж ахуйн нэгжүүдийн судалгаа гаргасан байна.</p> <p><i>Жилийн эцэс:</i> 2-оос доошгүй аж ахуйн</p>	<p>Усны нөөцөд учирсан хохирол, нөхөн төлбөрийг дараах 6 аж ахуйн нэгжид тооцсон. Үүнд:</p> <p>1. “СН трейд” ХХК-нд 16,956,656 төгрөгийн хохирол тооцон 2023.01.27-ны өдрийн 01/89 тоот албан бичгээр;</p> <p>2. “Монголиа флор спар” ХХК-нд 5,079,281 төгрөгний хохирол</p>	100 хувь

					<p>нэгжийн усны нөөцөд учирсан хохирлыг тооцох, нөхөн төлбөр тооцсон байна.</p>	<p>тооцон 2023.05.09-ны өдрийн 01/516 тоот албан бичгээр; 3. Нийслэлийн байгаль орчны газарт иргэн Б.Одхүүд холбогдох зөрчлийн дагуу 2,446,848 төгрөгийн хохирол тооцон 2023.05.23 өдрийн 01/589 тоот албан бичгээр; 4. “Доншен газрын тос (Монгол)” ХХК-нд 10,608,019 төгрөгийн хохирол тооцон 2023.05.24-ны өдрийн 01/590 тоот албан бичгээр; 5. “Элбэг хангалуун” ХХК, “Үзэсгэлэнт горхи тэрэлж” ХХК, “Хүч эблэ таун” ХХК, “Баяка трейд” ХХК-дад 2023.05.24-ны өдрийн 01/671 тоот албан бичгээр нийт 5,119,329 төгрөг; 6. “Газрын хүдэр” ХХК-нд 2023.07.05-ны өдрийн 01/821 тоот албан бичгээр 14,000,000 төгрөг; 7.“Эрдэнэс таван толгой” ХК-нд 5,230,876,320 төгрөгийн усны нөөцөд учирсан хохирол тооцон хүргүүлсэн байна. Нийт 5,285,086,453 төгрөгийн усны нөөцөд учирсан хохирол тооцон холбогдох байгууллага, аж ахуйн нэгжид хүргүүлсэн байна.</p>	
13.	<p>Зорилт 13. Монгол Улс, ОХУ-ын стратегийн түншлэл болон Монгол Улс, БНХАУ-ын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлэх: хилийн усны талаарх олон улсын гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх</p>	<p>Гол мөрөн, усны нөөцийн менежмент</p> <p>30 сая.төг</p>	<p>Хамтарсан шинжээчдийн багийн протокол</p> <p>Бүрэн эрхт төлөөлөгчдий</p>	<p>2019 оны хамтарсан Шинжээчдийн багийн протокол</p>	<p>Хамтарсан шинжээчдийн багийн протокол -1,</p>	<p>ОХУ-ын Засгийн газар хоорондын Бүрэн эрхт төлөөлөгчдийн XVII хуралдааныг зохион байгуулсан.</p>	100 хувь

			н XVI зөвлөгөөний протокол	2021 онд Хамтарсан ажлын хэсгийн хуралдааны протокол	Бүрэн эрхт төлөөлөгчдийн XVI зөвлөгөөний протокол-1		
13.1	Арга хэмжээ 1.13.1. “Хилийн усыг хамгаалах ашиглах тухай” МУ ба БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Шинжээчдийн багийн хуралдаан, МУ ба ОХУ-ын Засгийн газар хоорондын Бүрэн эрхт төлөөлөгчдийн XVI зөвлөгөөнийг зохион байгуулах	Гол мөрөн, усны нөөцийн менежмент 30 сая	Хамтарсан шинжээчдийн багийн протокол Бүрэн эрхт төлөөлөгчдийн XVI зөвлөгөөний протокол	Шинжээчдийн багийн хуралдааны протокол 2023 оны Хамтарсан ажлын хэсгийн хуралдааны протокол	<i>Эхний хагас жилд:</i> Бүрэн эрхт төлөөлөгчдийн XVII зөвлөгөөнийг зохион байгуулж, протокол-1 үйлдсэн байна. <i>Жилийн эцэст:</i> Хамтарсан шинжээчдийн багийн 2023-2024 оны ажлын төлөвлөгөөг баталсан протокол-1 үйлдсэн байна.	Монгол улс, ОХУ-ын хилийн усны хэлэлцээрийг хэрэгжүүлэх Монголын талын ажлын хэсгийн хуралдааныг 2023.11.10-нд зохион байгуулсан бөгөөд хуралдаанаар Сэлэнгэ мөрөн болон бусад хил дамнасан голуудын усны тоо хэмжээ буюу үер, урсцын асуудал, усны чанарын асуудлуудыг хэлэлцсэн. Монгол улс, ОХУ-ын хилийн усны хэлэлцээрийн Бүрэн эрхт төлөөлөгчдийн ээлжит 17-р хуралдааныг ОХУ-ын Эрхүү хотод 2023.11.27-28 өдрүүдэд зохион байгуулсан. Хуралдаанаар 2022-2023 онд хилийн усны чанар, эрүүл ахуй халдвар судлалын нөхцөл байдал, усны ашиглалт хамгаалалт, Сэлэнгэ мөрний урсац, үерийн байдал ямар байсан тухай асуудлуудаар мэдээлэл солилцож, 2024 оны хуралдаан хүртэл хийх ажлын төлөвлөгөөг баталсан. Дэлхий, хүн төрөлхтний хамгийн үнэт өв, цэвэр усны хамгийн том нөөц болох Байгал нуурыг хамгаалах нь найрсаг хөрш улсуудын хувьд тэргүүн зэргийн үүрэг бөгөөд Байгал нуурыг хамгаалах үндсэн арга нь түүний хамгийн том цутгал усны эх үүсвэр болох Сэлэнгэ мөрнийг хамгаалах ажил шаардлагатай. Сэлэнгэ мөрнийг хамгаалахын	100 хувь

						тулд түүний цутгал голууд, голын эхийг хамгаалж, үер ган гачгаас сэргийлэх, хамгаалах, хур тунадасны усыг хуримтлуулах шаардлагатай байгаа талаар талууд санал нэгдсэн.	
ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ							
14.1	<p>Арга хэмжээ 14.1. Усны газрын төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин, холбогдох нэмэгдлийг шинэчлэн баталсан тушаал гаргах, хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөнийг цаг тухайд нь Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлагын системд мэдээллийг оруулах. Шилэн дансанд хүний нөөцийн мэдээллийг хуулийн хугацаанд тавих</p>	Төсөв шаардахгүй	Усны газрын даргын тушаал гаргасан байна. Усны газрын хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөнийг цаг тухайд нь Хүний нөөцийн удирдлагын системд мэдээллийг оруулсан байна. Хүний нөөцийн мэдээллийг шилэн дансанд хуулийн хугацаанд нь тавьсан байна.	Усны газрын албан тушаалын тодорхойлолту удыг батлуулсан байна. Нийт 37 албан хаагчийг албан тушаалд томилсон тушаал гаргасан.	<p><i>Эхний хагас жил:</i> Усны газрын төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин, холбогдох нэмэгдлийг шинэчлэн баталсан тушаал гаргасан байна. Бүх албан хаагчид Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн удирдлагын системд орсон байна. Усны газрын хүний нөөцийн мэдээллийг шилэн дансанд хуулийн хугацаанд нь оруулсан байна.</p> <p><i>Жилийн эцэс:</i> Усны газрын төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин, холбогдох нэмэгдлийг шинэчлэн</p>	Усны газрын төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин, холбогдох нэмэгдлийг “Орон тоо, цалингийн санг шинэчлэн тогтоох тухай” Усны газрын даргын 2023.01.04 өдрийн А/05 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлагын системд Усны газрын төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний нийт 38 албан хаагчдын цалин, холбогдох нэмэгдлийг шинэчлэн оруулсан. Шилэн дансанд хүний нөөцтэй холбоотой 10 мэдээлэл оруулахаас 10 мэдээлэл оруулсан. “Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох тухай” Усны газрын даргын 2023 оны А/06 дугаар тушаалаар гаргасан. “Ээлжийн амралтын хуваарь батлах тухай” Усны газрын даргын 2023 оны А/09 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн албаны салбар зөвлөлд 2023.01.02 өдрийн 01/4 дүгээр албан бичгээр Усны газрын сул орон тооны нөхөх захиалгыг хүргүүлсэн.	100 хувь

					<p>баталсан тушаал гаргасан байна. Бүх албан хаагчид Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн удирдлагын системд орсон байна. Усны газрын хүний нөөцийн мэдээллийг шилэн дансанд хуулийн хугацаанд нь оруулсан байна.</p>	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигийн дагуу 2023.04.24 өдөр Тангараг өргөх ёслолын арга хэмжээг зохион байгуулж, Усны газрын 10 албан хаагч төрийн захиргааны албан хаагчийн тангараг өгөх арга хэмжээг зохион байгуулсан.</p>	
14.2	<p>Арга хэмжээ 14.2 Албан хаагчдын Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг шинэчлэн гаргуулж хуулийн хугацаанд нь мэдүүлэх ажлыг зохион байгуулах</p>	Төсөв шаардахгүй	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг	<p>Шинэчлэн гаргасан 32 албан тушаалтны 2021 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг баталгаажуулсан.</p>	<p>Эхний хагас жил: 2023 оны 2 дугаар сарын 15-ны дотор 27 албан тушаалтны 2022 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шинэчлэн гаргуулж, тайланг Авилагтай тэмцэх газарт хүргүүлсэн байна.</p> <p>Жилийн эцэс: Албан хаагчдын Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг шинэчлэн гаргуулж хуулийн хугацаанд нь мэдүүлэх ажлыг</p>	<p>2023 оны 2 дугаар сарын 15-ны дотор 24 албан тушаалтны 2022 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шинэчлэн гаргасан. ХАСХОМ-3, ХАСХОМ-4, ХАС хураангуйг PDF файлаар soyolmaa@iaac.mn цахим хаягаар болон ХАСХОМ-1 тайланг Усны газрын даргын 2023 оны 01/206 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газрын хяналт, шалгалт, дүн шинжилгээний хэлтэст хүргүүлсэн. Шинээр албан тушаалд томилдох 7 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газрын хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээр хянуулж, ХАСХОМ-ыг 30 хоногийн дотор мэдүүлэх ажлыг зохион байгуулсан.</p> <p>Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн 2023 оны хагас жил, жилийн</p>	100 хувь

					зохион байгуулсан байна.	эцсийн тайланг хуулийн хугацаанд цахимаар хүргүүлсэн.	
14.3	Арга хэмжээ 14.3. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд боловсруулж батлуулан, биелэлтийг улирал, хагас жил, жилийн эцсээр тайлагнаж, БОАЖЯ-ны холбогдох газар, хэлтэст хүргүүлэх.	Төсөв шаардахгүй	Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө Хагас жил, бүтэн жилийн гүйцэтгэлийн тайлан	Батлагдсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан.	Эхний хагас жил: 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд нь боловсруулж батлуулсан байна-1 Хагас жилийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэн хуулийн хугацаанд нь БОАЖЯ-нд хүргүүлсэн байна. Жилийн эцэс: Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн тайланг нэгтгэн, хуулийн хугацаанд нь БОАЖЯ-нд хүргүүлсэн байна.	Усны газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчин, орчин, аялал жуулчлалын яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газарт 2023.06.02 өдрийн 01/637 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг 2023.12.05 өдрийн 01/1394 дугаартай албан бичгээр	100 хувь
14.4	Арга хэмжээ 14.4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг нэгтгэн гаргаж БОАЖЯ-нд хүргүүлэх.	Төсөв шаардахгүй	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн /Усны газартай холбоотой 30-35 заалт/ биелэлт МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл /5 ажил/, ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны	Хууль тогтоомжийн /Усны газартай холбоотой 31 заалт/ биелэлтийн явцын тайлан, МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл /5 ажил/, ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт /5 ажил/ Усны газраас	Эхний хагас жил: Хууль тогтоомжийн биелэлтийн тайлан, МУЗГМХ, Үндсэн чиглэл, УАӨҮТ-ийн биелэлтийг чанартай боловсруулж БОАЖЯ-ны ХШҮДАГ-т хуулийн хугацаанд нь хүргүүлсэн байна.	Хууль тогтоомжийн биелэлтийн тайлан, МУЗГМХ, Үндсэн чиглэл, УАӨҮТ, Монгол улсын хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж БОАЖЯ-ны БНБЗГ-ын мэргэжилтэн Д.Даваанямд davaanyam2006@gmail.com цахим хаягаар тайлант хугацаанд тус бүр хүргүүлсэн. "Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний устай холбоотой арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг холбогдох хэлтсүүдээс авч нэгтгэж БОАЖЯ-ны мэргэжилтэн	100 хувь

			хөтөлбөрт /5 ажил/ Усны газраас орсон ажлуудын биелэлт УАӨҮТ-ийн биелэлт	хэрэгжүүлсэн ажлуудын биелэлтийн тайланг 2021 оны 12 сарын байдлаар нэгтгэн гаргаж БОАЖЯ-нд хүргүүлсэн.	<i>Жилийн эцэс:</i> Хууль тогтоомжийн биелэлтийн тайлан, МУЗГМХ, Үндсэн чиглэл, УАӨҮТ-ийн биелэлтийг чанартай боловсруулж БОАЖЯ-ны ХШҮДАГ-т хуулийн хугацаанд нь хүргүүлсэн байна.	А.Мөнхбатад tuugii.boaju@gmail.com цахим хаягаар хүргүүлсэн.	
14.5	Арга хэмжээ 14.5. Иргэн, аж ахуйн нэгж, мэргэжлийн байгууллагаас Усны газарт ирүүлсэн албан бичгийн хариуг хуулийн хугацаанд нь гаргаж шийдвэрлэх	Төсөв шаардахгүй	Хүлээн авч, шийдвэрлэсэн албан бичиг, өргөдлийн тоо	2022 онд 1706 бичгийн хариуг шийдвэрлэсэн.	<i>Эхний хагас жил:</i> Иргэн, аж ахуйн нэгжээс Усны газарт ирүүлсэн 700 албан бичгийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн байна. <i>Жилийн эцэс:</i> Иргэн, аж ахуйн нэгжээс Усны газарт ирүүлсэн 1500 орчим албан бичгийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн байна.	Тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн 1750 албан бичгийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн байна. Үүнээс: Шийдвэрлэсэн - 1549 Хариутай –983 Хариугүй - 566 Судлагдаж байгаа – 201 Хариутай – 120 Хариугүй – 81 бичиг байна.	100 хувь
14.6	Арга хэмжээ 14.6. Усны нөөц түүнийг зохистой хамгаалах, ашиглах чиглэлээр олон улсын байгууллагатай хамтран ажиллах төслийн санал боловсруулж шинэ төсөл, хөтөлбөр эхлүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллах	Төсөв шаардахгүй	Олон улсын байгууллага, элчин сайдын яам, төсөл хөтөлбөрт хүргүүлсэн хамтран ажиллах санал 3-5	Усны газарт хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр байхгүй. Шинээр эхлүүлнэ.	<i>Эхний хагас жил:</i> 2-3 олон улсын байгууллага, элчин сайдын яам, төсөл хөтөлбөрт хүргүүлсэн санал <i>Жилийн эцэс:</i> 3-5 олон улсын байгууллага, элчин сайдын яам, төсөл	Орхон аймгийн Жаргалант сум, Дархан-Уул аймгийн Хонгор сум, Шарын гол сум, Төв аймгийн Жаргалант суманд гадаргын усыг ундны усны стандартад хүртэл цэвэршүүлж, сумдын хүн амын унд ахуйн хэрэгцээнд түгээх инженерийн шугам сүлжээг Койка-гийн төслийн буцалтгүй тусламжаар	100 хувь

					хөтөлбөрт хамтран ажиллах санал хүргүүлсэн байна.	хийлгэхээр хамтран ажиллаж байна. ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр Сав газрын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулах, мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулах, хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж, бэлтгэл ажлын хүрээнд талууд 3 удаагийн уулзалт зохион байгуулаад байна. Тус байгууллагын дэмжлэгтэйгээр Туул голын сав газрын УННМТ-г шинэчлэн боловсруулах, сав газрын захиргааны албан хаагчдыг чадваржуулах сургалт зохион байгуулахаар шийдвэрлэсэн.	
14.7	Арга хэмжээ 14.7. Сургалт сурталчилгаа, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах: Усны салбарын боловсон хүчнийг бэлтгэх, чадавхыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах	Хувийн хэвшил, Төсөл хөтөлбөр	Усны зүй зохистой хэрэглээний тухай хийсэн 20-иос цөөнгүй ярилцлага, нэвтрүүлэг мэдээллийн чанар Дэлхийн усны өдрийг зохион байгуулсан байдал	2021 онд “Гүнээсээ хайрлая” усны аяны хүрээнд 1 онлайн үзэсгэлэн, сонирхогчдын гэрэл зургийн уралдаан, 10 бүтээлч постер, 3 видео шторк, 1 нэвтрүүлэг бэлтгэн Усны газрын фэйсфүүк, пэйж хуудсаар байршуулсан нь нийт давхардсан	<i>Эхний хагас жил:</i> “Гүнээсээ хайрлая” усны аянг зохион байгуулж, 10 бүтээлч постер, 3 видео шторк, 1 нэвтрүүлэг бэлтгэн Усны газрын фэйсфүүк, пэйж хуудсаар байршуулсан байна. <i>Жилийн эцэс:</i> “Гүнээсээ хайрлая” усны аяны хүрээнд 20-иос цөөнгүй ярилцлага, нэвтрүүлэг	“Гүнээсээ хайрлая” усны аянг Оюу толгой компанитай 2 дахь жилдээ хамтран зохион байгуулж, 10 бүтээлч постер, 3 видео шторк, 1 нэвтрүүлэг бэлтгэн Усны газрын фэйсфүүк, пэйж хуудсанд байршуулсан. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Цэнхэр Алт” усны салбарын үндэсний чуулганыг 2023.03.23 өдөр зохион байгуулсан. “Өөрчлөлт, сэргэлтийг хурдасгая” уриан дор Усны салбарын тулгамдсан асуудлууд, шинжлэх ухааны ололт, инноваци технологийн шийдлүүдийг хэлэлцэх	100 хувь

				тоогоор 1 сая хүн үзэж 600 мянган хүн эерэг сэтгэгдэл илэрхийлсэн байна.	мэдээлэл бичиж хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсан байна.	зорилготой. Чуулганд Мянганы сорилтын сан, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Хайнс зайделийн сан, “Усны түншлэл” ТББ, Дэлхийн байгаль хамгаалах сан болон 12 элчин сайдын яам, нийт 1000 гаруй төлөөлөл оролцсон. “Цэнхэр Алт” усны салбарын үндэсний чуулган хамгийн үзэлттэй байлаа. Нийт 6 видео хийснээс Хэрлэн голыг 9400, Цойцон нуурыг 37400, Байдраг голыг 32400, Хөвсгөл нуурыг 3700, Туул голыг 5500, Салбар хуралдааны нэгтгэлийг 8700, шууд дамжуулалтыг 5700, тодруулга яриаг 2900, Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Усны газрын пейж хуудас дээр 156200 хүнд тус бүр хүрчээ. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Ерөнхийлөгчийн тамгын пейж хуудаснаас 12400 хүнд хүргэсэн байна. Мөн ИЙГЛТВ-3800, ТВ-9-4400, MNB-4500 гаруй хүн үзсэн.	
14.8	Арга хэмжээ 14.8. Байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах санхүүжилтийг эрх бүхий байгууллагуудаар батлуулж, санхүүгийн үйл ажиллагааг батлагдсан төсвийн хүрээнд үр дүнтэй зарцуулж, сар, улирал, хагас жил, жилийн эцсийн тайлан мэдээг хуулийн хугацаанд нь гаргах	Төсөв шаардахгүй	2022 оны санхүүгийн тайлан Үндэсний аудитын дүгнэлт 2023 оны хагас жилийн санхүүгийн тайлан		<i>Эхний хагас жил:</i> 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан-1, Үндэсний аудитын дүгнэлт-1. 2021 оны санхүүгийн жилийн тайлан, тайлант хугацааны /өссөн дүнгээр/ урсгал санхүүжилтийн болон нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	Усны газрын 2022.12.01 өдрөөр нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн гаргасан тул Үндэсний аудитын газрын 2023 оны 01/677 дугаар албан бичгээр өөрчлөлтгүй дүгнэлт авсан байна. 2023.06.30 өдрөөр нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Улсын секторын нягтлан бодох	100 хувь

					Жилийн эцэс: 2023 оны хагас жилийн санхүүгийн тайлан-1	бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн гаргасан.	
14.9	Арга хэмжээ 14.9. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах	Төсөв шаардахгүй	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлан Аудитын дүгнэлт Сав газрын захиргаадын 2023 оны хагас жилийн санхүүгийн тайлан		Эхний хагас жил: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан-1 хуулийн хугацаанд нь чанартай гаргаж, аудит хийлгэж, харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж нэгтгүүлсэн байна. Жилийн эцэс: Сав газрын захиргаадын санхүүгийн тайланг 2023 оны хагас жилээр нэгтгэж, харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж нэгтгүүлсэн байна.	Усны газар нь 2023.11.30 байдлаар Төсвөөс урсгал санхүүжилт 1.975,6 сая төгрөг, Ус ашигласны дүгнэлт гаргасны үйлчилгээний 851.7 сая төгрөгийн орлого олж нийт урсгал зардал 2.150.1 сая төгрөг, цалин 577.7 сая төгрөг, НДШ 73.5 сая төгрөг, байр ашиглалтай холбоотой зардал 19.3 сая төгрөг, хангамж бараа материалын зардал 31.0 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 55.5 сая төгрөг, Томилт 19.9 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 1.230.6 сая төгрөг зарцуулж. Тэтгэвэрт гарсан нэг иргэнд 107.1 сая төгрөг олгосон.	100 хувь
14.10	Арга хэмжээ 14.10. Төсвийн ил тод байдлыг хангах	Төсөв шаардахгүй	Шилэн дансанд оруулсан мэдээний тоо	2023 онд Шилэн дансны мэдээллийг тухай бүр, сар улирал, хагас жил, жилээр цаг хугацаанд нь нийт 163	Эхний хагас жил: Байгууллагын болон ажиллагсдын мэдээлэл, худалдан авалтын мэдээллийг тухай бүр 13, сар бүр 3,	Усны газрын шилэн дансанд байгууллагын болон ажиллагсдын мэдээлэл, худалдан авалтын зэрэг 38 мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулсан байна.	100 хувь

				мэдээллийг оруулсан.	улиралд 42, хагас жилд 81 мэдээлэл цаг хугацаанд нь оруулсан байна. <i>Жилийн эцэс:</i> Байгууллагын болон ажиллагсдын мэдээлэл, худалдан авалтын мэдээллийг тухай бүр 13, сар бүр 3, улиралд 42, хагас жилд 81, бүтэн жилд 163 мэдээлэл цаг хугацаанд нь оруулсан байна.		
ХОЁРДУГААР ХЭСЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
15.1	Арга хэмжээ 15.1 “Монгол Улсын Засгийн Газар, АНУ-ын Мянганы Сорилтын Корпорац хооронд байгуулсан II компакт гэрээний хүрээнд хэрэгжүүлж буй “Усны өгөгдлийн удирдлагын систем” хөгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Төсөв шаардахгүй	Усны өгөгдлийн удирдлагын системийг хүлээн авсан байна.	Шинээр хийгдэнэ.	<i>Эхний хагас жил:</i> “Усны өгөгдлийн удирдлагын систем хөгжүүлэх ажлыг зохион байгуулж, prototype хувилбарыг хүлээн авсан байна. <i>Жилийн эцэс:</i> Бүрэн хөгжүүлсэн “Усны өгөгдлийн удирдлагын системийг” хүлээн авч, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна.	“Усны өгөгдлийн удирдлагын систем” хөгжүүлэх ажил төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа бөгөөд холбогдогч талуудтай нийт 10 удаагийн уулзалтыг зохион байгуулж, хэлэлцүүлэг хийж, санал солилцож ажилласан бөгөөд системийг хүлээж авах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	70 хувь
	Арга хэмжээ 15.1.1 Төрийн үйлчилгээг цахимжуулах, төрийн үйлчилгээний нэгдсэн системийн хэвийн ажиллагааг хангах, хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	Төсөв шаардахгүй	Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоол	Шинээр хийгдэнэ.	<i>Эхний хагас жилд:</i> Нээлттэй байх 98 төрлийн мэдээллийг water.gov.mn цахим сайтад	Засгийн газрын shilen.gov.mn цахим сайтад нээлттэй байх 98 төрлийн мэдээллийг байршуулсан Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ 90 хувь байна.	100 хувь

					байршуулсан байна.	<p>Мөн opendata-д Усны газрын 14 мэдээллийг оруулсан.</p> <p>И-Монголиа цахим системээр ирүүлсэн 43 хаягдал усны дүгнэлт гаргуулах хүсэлтийг 100% шийдвэрлэж, ААНБ-уудад дүгнэлтийн тавигдах шаардлага хэсэгт дараа оны дүгнэлтийг цахимаар ирүүлэхийг мэдэгдэн ажиллаж байна.</p> <p>Усны газрын https://water.gov.mn/ веб сайтын Үйлчилгээ цонхны Хаягдал усны дүгнэлт цонхонд Бүрдүүлэх материалын жагсаалт болон Усны газрын 2020-2023 онд хаягдал усны дүгнэлт гаргуулсан ААНБ-ын мэдээллийг хуулийн этгээдийн нэр, холбоо барих утасны дугаар, төсөл хэрэгжүүлж буй хаяг, байршил, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, регистрийн дугаар, хаягдал усны хэмжээ, ногдуулсан төлбөрөөр гарган байршуулсан.</p> <p>Сав гарын захиргаа цонхонд 21 СГЗ-ны танилцуулга, эрхэм зорилго, хариуцсан газар нутгийн зураглал бүхий мэдээллийг байршуулсан.</p> <p>Мэдээ мэдээлэл цонхонд Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт гарчигтайгаар Улсын хэмжээнд 2020-2023 онд ногдуулсан, чөлөөлсөн, хөнгөлсөн ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ болон Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого, унд ахуй болон технологийн хаягдал усны хэмжээг инфографикаар байршуулсан.</p>	
--	--	--	--	--	--------------------	---	--

						Эрх зүйн актууд цонхонд Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, дагалдах дүрэм, журмуудыг байршуулсан.	
15.2	<p>Арга хэмжээ 15.2 МУ-ын Засгийн газар “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв”-ийн санал, гомдол хүлээн авах, шийдвэрлэх цахим хуудсыг хариуцан ажиллуулах</p>	Төсөв шаардахгүй	Хүлээн авч, шийдвэрлэсэн санал, гомдлын тоо	2022 онд 6 өргөдөл ирсэн. Жил бүр хийгдэнэ.	<p><i>Эхний хагас жил:</i> Иргэд, байгууллагуудаас ирүүлсэн санал, гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэж, тайлан мэдээг нэгтгэн гаргаж, үр дүнг тайлагнасан байна /тоон мэдээлэл/.</p> <p><i>Жилийн эцэс:</i> Иргэд, байгууллагуудаас ирүүлсэн тайлан мэдээг нэгтгэн гаргаж, үр дүнг тайлагнасан байна.</p>	2023 оны жилийн эцсийн байдлаар 11-11 төвд 11 гомдол, санал ирсэн бөгөөд тухайн санал ирүүлсэн иргэнтэй холбогдож, хуулийн хугацаанд холбогдох тайлбар, мэдээллийг өгч ажилласан.	100 хувь
15.3	<p>Арга хэмжээ 15.3. Усны хяналтын төв лабораторийн үйл ажиллагааг хэвийн явуулах, лабораторид ирсэн усны хими, микробиологи, хүнд металлын химийн шинжилгээний үр дүнг хянаж, мэдээлэх, мэргэжил арга зүй, удирдлагаар хангах;</p>	Лабораторийн өөрийн орлогоос	Шинжилгээний тоо	2022 онд Цэвэр усны 949, бохир усны 200, хүнд металл 235, цэвэр усны нян судлал 620, бохир усны нян судлал 82, хөрсний 5 сорьцонд химийн шинжилгээ хийгдсэн байна.	<p><i>Эхний хагас жил</i> Цэвэр усны хими 400, бохир усны хими 115, хүнд металл 100, цэвэр усны нян судлал 315, бохир усны нян судлал 70, хөрсний 2 сорьцонд химийн шинжилгээг хийж гүйцэтгэнэ.</p> <p><i>Жилийн эцэст:</i> Цэвэр усны хими 400, бохир усны хими 115, хүнд</p>	Усны хяналтын төв лаборатори нь 2023 онд цэвэр усны 1141, бохир усны 494, хүнд металлын 974, цэвэр усны нян судлалын 416, бохир усны нян судлалын 356, хөрсний 30 сорьц, нийт 3411 сорьцонд лабораторийн шинжилгээ хийж улсын төсөвт 114.5 сая төгрөг төвлөрүүлж ажилласан. БОАЖЯам, Байгаль орчны судалгаа шинжилгээний төв, НБОГ, салбарын хяналтын газар болон дотоодын хяналт шалгалтын захилгаар цэвэр усны 786 сорьц, бохир усны 312	100 хувь

				металл 100, цэвэр усны нян судлал 315, бохир усны нян судлал 70, хөрсний 3 сорьцонд химийн шинжилгээг хийж гүйцэтгэнэ.	сорьц, хүнд металлын 800 сорьц, бохир усны бичил амь судлалын 312 сорьц, нийт 2210 сорьцод 124.28 сая.төгрөгийн шинжилгээг төлбөргүй хийж гүйцэтгэсэн.	
--	--	--	--	--	--	--

**ГУРАВ. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН
БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ**

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	8	8	1. Нэг удаагийн сургалтын хугацаа 4 цагаас дээш бол тайлагнана. 2.Зорилтот түвшин хэсэгт байгууллагын сургалтын төлөвлөгөөнд туссан дүнг бичнэ. 3.Гадаад улс орон, хилийн чандад хамрагдсан сургалтыг тайлагнана. 4. Дэлгэрэнгүй судалгаа мэдээллийг тайланд хавсаргасан байна.
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	2	2	
			Мэргэшүүлэх сургалт	5	5	
			Туршлага солилцох арга хэмжээ	-	-	
			Бусад “Цэнхэр Алт “ усны салбарын үндэсний чуулган зохион байгуулсан.	4	4	
		1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	1215	1215	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	684	531	
			Эрэгтэй албан хаагч	-	434	
			Удирдах албан тушаалтан		25	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан		1013	
1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш	100 хувь			
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	3	3	
		2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	5	5	

	чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	13Үүнээс	Эмэгтэй албан хаагч	3	-	
			Эрэгтэй албан хаагч	-	2	
			Удирдах албан тушаалтан	--	-	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	5	
		2.3.	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	20-оос дээш	1 хувь	
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-		
		3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	2.5 хувь	13.5 хувь
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						
4.	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь		31.7 хувь	500.141.443,95 төг. 31.7 хувь
		4.2.	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)		4.9 хувь	77.599.998,99 төг 4.9 хувь
5.	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1.	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	80-аас дээш	-	
6.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	1-ээс дээш	1 удаа	Усны газрын албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт 2023 оны 1 дүгээр улиралд багтаан оруулсан.
		6.2.	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш	100 хувь	
7.	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1.	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)			Тэтгэвэрт гарсан 3 албан хаагчид нийт 107,1 сая төгрөгийн тэтгэмж олгосон.

**ДӨРӨВ. ӨМНӨХ ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНӨӨС БИЕЛЭЭГҮЙ, ЦААШИД ҮРГЭЛЖЛҮҮЛЭН
ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

1	2	3	4	5	6	7	8
Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1.4	Зорилт 1.4. Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хамгаалалтанд авах	Улсын төсөв	Арга хэмжээ Ажлын явцад хяналт тавьсан байдал	Аварга тосон нуурыг хамгаалах ажлын зураг, төсөв хийгдсэн. Бөөрөгийн цагаан нуур сэргээх ажлын ус дөхүүлэх сувгийн ажлын гүйцэтгэл 80%.	Аварга тосон нуурыг хамгаалах ажлыг 100% хэрэгжүүлсэн байна. Ажил гүйцэтгэх гэрээг сунгаж, батлагдсан ажлын даалгаврын дагуу ажлын гүйцэтгэлийг хүлээн авч, Бөөрөгийн Цагаан нуур сэргэсэн байна.	Аварга тосон нуурыг бохирдолт ширгэлтээс хамгаалах ажлын зураг, төсвийн ажлын үр дүнд хүлээн авсан. Бөөрөгийн Цагаан нуур сэргээх ажлын гүйцэтгэлийг улсын комисс хүлээн авсан.	90 хувь
1.4.1	Арга хэмжээ 1.4.1. Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагдахь Аварга тосон, Зүүн бүрд нууруудыг сэргээх ажил /2022-2023 онд хийгдэнэ/	Улсын төсөв 966.2 сая.төг	Арга хэмжээ Ажлын явцад хяналт тавьсан байдал	Аварга тосон нуурыг хамгаалах ажлын зураг, төсөв хийгдсэн.	<i>Эхний хагас жил:</i> Аварга тосон нуурыг хамгаалах ажлыг 50% хэрэгжүүлсэн байна. Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, явцын гүйцэтгэлийн тайланг хүлээн авсан байна. <i>Жилийн эцэс:</i> Аварга тосон нуурыг хамгаалах ажлыг 100% хэрэгжүүлсэн байна. Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг хүлээн авсан байна.	“VI.1.15 Аварга тосон, Бүрд нууруудыг сэргээх /Хэнтий, Дэлгэрхаан сум/ ажлын багц 1 Гэрээ БОАЖЯ/20221100501 “Бүрд нуурыг сэргээх ажил”-ын гүйцэтгэгчээр “Усны барилга” ХХК, багц 2 Гэрээ БОАЖЯ/20221100502 “Аварга тосон нуурыг сэргээх ажил”-ын гүйцэтгэгчээр “Престиж-Инженеринг” ХХК-иуд тус тус шалгарч 2022.04.14-ний өдөр гэрээ байгуулсан. Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт орших “Аварга тосон” нуурын суурь судалгааны ажлыг 2022 онд гүйцэтгэж захиалагчид хүлээлгэн өгсөн. “Престиж инженеринг” ХХК-тай ажил гүйцэтгэх тухай гэрээг	100 хувь

1	2	3	4	5	6	7	8
						байгуулж ажил гүйцэтгэх хугацааг 2023.11.30 өдөр хүртэл сунгасан. Гүйцэтгэгч компаниас Аварга тосон нуурын судалгааны ажлын тайлан болон Аварга тосон нуурыг бохирдолт ширгэлтээс хамгаалах, сэргээх зураг төслийг 2023.03.27-ны өдөр манай газарт танилцуулж, холбогдох санал, зөвлөмж авч, тайланг хүлээлгэн өгсөн. Барилга угсралтын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн бөгөөд 2023.11.06-ны өдөр улсын комисст хүлээлгэн өгсөн.	
1.4.2	Арга хэмжээ 1.4.2. Архангай аймгийн Эрдэнэмандал сумын нутаг дахь Бөөрөгийн цагаан нуур сэргээх ажил	Гол мөрөн, усны нөөцийн менежмент 23.4 сая.төг	Арга хэмжээ	2021 оны ажлын гүйцэтгэл Ус дөхүүлэх сувгийн ажил 80%, ус зүй, нуурын усны балансын тооцоо, судалгаа, шинжилгээний ажлууд хийгдсэн.	<i>Эхний хагас жил:</i> БОАЖЯ-ны ТНБД-ын 2021.10.20-ны 03/4950 албан бичгийн дагуу ажил гүйцэтгэх гэрээг сунгах, ажлын явцад хяналт тавьж ажилласан байна. Ажил гүйцэтгэх гэрээг сунгаж, батлагдсан ажлын даалгаврын дагуу ажлын гүйцэтгэлийг хүлээн авч, Бөөрөгийн Цагаан нуур сэргээсэн байна.	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021.12.11 өдрийн Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлэх тухай А/392 дугаар тушаалын 3 дугаар хавсралтыг үндэслэн Архангай аймгийн Эрдэнэмандал сумын нутаг дахь Бөөрөгийн цагаан нуур сэргээх ажлыг гүйцэтгэгч “Аригшан” ХХК-тай ажил гүйцэтгэх 20/261 тоот гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан, ажил гүйцэтгэж дуусах хугацааг 2023.11.01-ний өдөр хүртэл сунгасан бөгөөд ажлын гүйцэтгэлийг 2023.12.05-ны өдөр Барилга байгууламжийг	100 хувь

1	2	3	4	5	6	7	8
						ашиглалтад оруулах комисст хүлээлгэн өгсөн.	
1.4.3	<p>Арга хэмжээ 1.4.3: Усны өрөмдлөгийн ажлын тууш метрийн үнэлгээг тооцож, зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлэх, жишиг үнэлгээ гаргах;</p>	Гол мөрөн, усны нөөцийн менежментийн төсөв 20.0 сая.төг	Усны салбарын өрөмдлөгийн ажлын жишиг үнэлгээ	Шинээр	<p><i>Эхний хагас жил:</i> Усны салбарын өрөмдлөгийн ажлын жишиг үнэлгээ хийх ажлын даалгаврыг боловсруулж батлуулан, сонгон шалгаруулалт явуулах ажлыг зохион байгуулан, гэрээ байгуулсан байна.</p> <p><i>Жилийн эцэс:</i> Усны салбарын өрөмдлөгийн ажлын боловсруулсан жишиг үнэлгээнд санал авч, жишиг үнэлгээг батлуулахаар БОАЖЯ-нд хүргүүлсэн байна.</p>	<p>"Эрдэнэдрийлинг" ХХК-тай 2022.08.02 өдөр 2022/11 дугаартай гэрээг байгуулсан бөгөөд гүйцэтгэгч байгууллагын албан хүсэлтийн дагуу 2023.09.29-ний өдөр хүртэл гэрээг сунгасан.</p> <p>"Эрдэнэдрийлинг" ХХК нь Олон улсад мөрдөгдөж байгаа ижил төстэй норм, стандартуудаас АНУ, Австрали, ОХУ-д мөрдөгдөж байгаа нийт 13 стандарт, ном, гарын авлагыг орчуулах ажил хийгдэж, ажлын явц 80 хувьд хүрсэн бөгөөд мэргэжлийн байгууллагууд болон холбоод, гүйцэтгэгч байгууллагын хувьд энэ стандартад нийцүүлэн нэгжийн үнэлгээг хийх нь илүү бодит бөгөөд үр дүнтэй гэж үзсэн учраас стандартыг бүрэн орчуулахаар ажиллаж байна. Стандартын орчуулгын ажил дууссаж энэ ондоо багтаан нээлттэй хэлэлцүүлэг хийнэ.</p>	70 хувь

---oO---